

## ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, Мягмар гараг

### Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	1-7
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	8-52
<b>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</b>	9-10
<b>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/</b>	10-13
<b>3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/</b>	13-43
<b>4.Цусны донорын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	44-49
<b>5.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	49-52

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны  
05 дугаар сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 23 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: П.Ганзориг, С.Эрдэнэбат;  
Чөлөөтэй: Ш.Бямбасүрэн;  
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа, Н.Монголмаа, Б.Цогзолбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Л.Энхнасан:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 8  
Бүгд: 22

63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, О.Батнайрамдал, Ж.Баясгалан, М.Нарантуяа-Нара, М.Сарнай, Л.Энхнасан нар ажиллахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Отгонтунгалаг, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэд захирал Ч.Баттулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, мөн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Ц.Мөнхтуяа, П.Наранбаяр, Б.Бейсен нар үг хэлэв.

**Л.Энхнасан:** “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 6

Бүгд: 23

73.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа ажиллахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Анар, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнгөнсүх, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төсвийн

хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга Б.Төгөлдөр, Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга З.Райымбек, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар, Л.Отгонтуяа, А.Энхбат, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Туяа, Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Л.Мөнхцэцэг, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа, Б.Цогзолбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Б.Бейсен, Ж.Баясгалан, О.Батнайрамдал, М.Нарантуяа-Нара, Б.Хэрлэн, Ц.Мөнхтуяа, П.Наранбаяр, Ж.Галбадрах, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн А.Энхбат, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав*

***Дөрөв.Цусны донорын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын төрөлжсөн мэргэшлийн тусламж хариуцсан ахлах шинжээч М.Оюунчимэг, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Үйлдвэрлэлийн тасгийн технологич их эмч Н.Халиун, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Цусны чанар аюулгүй байдлын албаны дарга Э.Тунгалагтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай ялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу санал хураалт явуулав.*

**Л.Энхнасан:** 1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль,” гэснийг хасаж, мөн хэсгийн “Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэсний дараа “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17  
Татгалзсан: 9  
Бүгд: 26  
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлийг нэгтгэн 19 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах,  
урамшуулах, дэмжлэг үзүүлэх**

19.1.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагааг Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага нь цусны донорыг элсүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагаанд сайн дурын ажилтан, иргэн оролцож болно.

19.4.Цусны байнгын донорт цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн тооноос хамаарч Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагаас баталсан журмын дагуу энэ хуулийн 10.2.10-т заасан тэмдгийг олгоно.

19.5.Цусны донорыг “Цусны хүндэт донор” цол тэмдгээр дараах шалгуурын дагуу шагнаж, алдаршуулна:

19.5.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.2.цусаа 35 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.3.ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш удаа өгсөн.

19.6.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

19.7.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

19.8.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувилалд Засгийн газраас тогтоосон сувиллын жишиг үнийн дагуу жилд нэг удаа сувилуулах бөгөөд холбогдох журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.9.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор аймаг, нийслэлийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчино.”

19.10.“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүндэт донор”, “Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүндэт донор” цол тэмдэгтэй иргэнд энэ хуулийн 19.8, 19.9-д заасан дэмжлэг хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Цусны чанар аюулгүй байдлын албаны дарга Э.Тунгалагтуяа нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тээвэрлэх үйл ажиллагааг” гэсний дараа “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 15.1.12-т заасан” гэж нэмж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.12-т заасан эрүүл мэндийн байгууллага нь цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах зориулалтаар тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглан энэ хуулийн 22.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 7  
Бүгд: 26  
73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 25.4 дэх хэсгийн “сан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр цусны төв, цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудтай” гэснийг “эрүүл мэндийн мэдээлэл солилцооны нэгдсэн системтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 25.5 дахь хэсгийг хасах:

“25.3.Энэ хуулийн 25.2-т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагаа нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18  
Татгалзсан: 8  
Бүгд: 26  
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 52 минутад хэлэлцэж дуусав

***Тав.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваажаргал, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцын төсвийн урсгал зарлага хариуцсан шинжээч Э.Номин-Эрдэнэ нар оролцов.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлэв.

**Л.Энхнасан:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Н.Алтаншагай, Д.Бум-Очир, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа, М.Сарнай, Г.Хосбаяр,

Л.Энхнасан /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн “тэр үед гурав хүртэлх насанд нь” гэснийг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 17 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 40 минут үргэлжилж, ирвэл зохих 30 гишүүнээс 26 гишүүн хүрэлцэн ирж, 86.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 03 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН

БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.ГАНЗОРИГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
14 цаг 23 минут.

### ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энхнасан:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн ирсэн байна. Гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 5 сарын 12-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя.

Аюушийн Ариунзаяа, Буланы Бейсен, Мөнгөнцогийн Ганхүлэг, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Ганбатын Хосбаяр, Отгоншарын Батнайрамдал, Дуламын Бум-Очир, Сархадын Зулхпар, Дүгэрийн Рэгдэл, Бадарчийн Хэрлэн, Доржзовдын Энхтуяа, Жадамбаагийн Баясгалан, Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Мягмардашийн Сарнай, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Мөнхчулууны Энхцэцэг, Лутаагийн Энхнасан нар ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр 4 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл. Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай ажлын хэсэг байгуулах.

Хоёрт, Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчдийн сонсголыг товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/

Гуравдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028 он, 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 5 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг.

Дөрөвдүгээрт, Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нарын 4 гишүүдээс 2025 оны 3 сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Тавь дахь, Олон хүүхэд төрүүлж өсгөсний эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа, Баасанжаргал, Баярбаатар, Уянга, Эрдэнэбат, Эрдэнэболд нарын 6 гишүүнээс 2025 оны 6 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун нарын 24 гишүүнээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн /Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай/ Байнгын хорооны ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЬЕ.**

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Ажлын хэсэг байгуулах тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун нарын 24 гишүүнээс 2025 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн ажлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах ажлын хэсгийн ахлагчаар ажиллах гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсэг ахлагчаар одоогоор Ганхүлэг, Улсын Их Хурлын гишүүдэд Алтаншагай Улсын Их Хурлын гишүүн, Батнайрамдал Улсын Их Хурлын гишүүн, Баясгалан Улсын Их Хурлын гишүүн, Энхнасан Улсын Их Хурлын гишүүд одоогоор орохоор байна. Өөр орох гишүүд байна уу? Энэ бас чухал хууль шүү нийгмийн ажлын тухай. Тийм байна. Энд бас энэ 4-хөн хүн, 5 хүн болчихоод байна л даа. Өшөө 2 хүн орчихвол.

Тэгье Нарантуяа-Нара Улсын Их Хурлын гишүүн орно. Хүрээ нь байхгүй байх даа. Энэ 6 болоод байна. 7 бол бас Сарнай орох юм уу тээ? Сарнай бас намаа төлөөлөөд өргөн мэдүүлчихсэн үү? Өргөн барьсан. Тэгвэл ингээд Сарнай гишүүнийг оруулаад ингээд 7 хүний бүрэлдэхүүнтэй о о бүх намын төлөөлөлтэй ингээд ажлын хэсэг байгуулж байна.

Хоёрдугаарт, ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагуудын албан тушаалтныг тухайн бүр татан оролцуулж ажиллахыг ажлын хэсэг Ганхүлэгт зөвшөөрсүгэй. Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Ганзориг.

Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Санал хураалтдаа бэлдэнэ үү. Наранбаяр сайд санал хураалтдаа бэлдэнэ үү. Энхтуяа гишүүн санал хураалтдаа. Санал хураалт.

Санал хураалтад 22 гишүүнээс 14 гишүүн дэмжиж, 63.6 хувиар дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн хэлэлцэх асуудалд оръё.

14.34 цаг

**“Нэр дэвшигчийг сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.1.2-т даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвслээс 3 хүн гэж, 35.1.3-т ажил олгогчдыг төлөөлж ажил олгогчдын олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагаас 3 хүн гэж заасан. Мөн хуулийн 35.4-д Улсын Их Хурал энэ хуулийн 35.3-д заасан нэр дэвшигчдийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилж, чөлөөлнө гэж заасан. 35.8-д Үндэсний зөвлөлийн гишүүн хуульд заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болохоос өмнө чөлөөлөгдөх тохиолдолд дараагийн гишүүнийг энэ хуулийн 35.3-д заасны дагуу сонгон шалгаруулж чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар Улсын Их Хурлаас томилно гэж заасан.

Энэ хүрээнд Улсын Их Хурлаас 2022 оны 7 сарын 6-ны өдөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр томилогдсон Буянжаргал, Б.Баяраа нар нь Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооноос тус 2 гишүүнийг чөлөөлж, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны ерөнхийлөгч Э.Тамир, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны залуучуудын хорооны дарга Б.Галбадрах нарыг Улсын Их Хурлаас 2021 оны 4 сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр томилсон Л.Төр-Од нар нь Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн тул Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас Л.Төр-Одыг чөлөөлж, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын Ерөнхийлөгчийн зөвлөх М.Сарандавааг нэр дэвшүүлж, томилох хүсэлтийг Байнгын хороонд тус тус ирүүлсэн болно.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Өнөөдөр сонсголын тов, сонсгол даргалагчийг томилно. Сонсголын товыг өнөөдрөөс хойш доор хаяж 14 хоногийн дараа тогтоох дэгийн заалтын хүрээнд хамгийн боломжит өдөр нь 5 сарын 25-ны өдөр болж байна. Түүнчлэн ирэх 7 хоногт нэр дэвшигчдийн мэдлэг, мэргэжил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчийг томилохоор байгааг бас дуулгая.

Ингээд хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Отгонтунгалаг Монголын үйлдвэрчний эвслийн холбооны Ерөнхий нарий бичгийн дарга, Баттулга Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын Дэд захирал.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Тийм нэр дэвшигч тогтоолын. Төсөл хамаагүй. Тогтоолын. Төсөл тогтоолын төслийг танилцуулчихъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол “Нэр дэвшигчийг дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай”,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1, 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Нэгдүгээрт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даатгуулагч ажил олгогчийг төлөөлсөн гишүүн Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан нэр дэвшигчийн энэ сонсголыг 2026 оны 2 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулахаар товлосугай.

Хоёрдугаарт, Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүнийг томилсугай.

Гуравдугаарт, Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлж бэлтгэл ажлыг хангаж холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо Ганзориг, мэргэжил, арга зүйн техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар Өлзийсайханд тус тус даалгасугай. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдааны даргалагч Л.Энхнасан ийм тогтоол байгаа.

Асуулт асуух гишүүд байна уу? Тийм, тэгээд бас хурлыг даргалах гишүүн бас саналаа хэлж болно. Асуулт дараа нь үг байгаа. Дараа нь үг байгаа. Яах вэ дэгээрээ асуулт асуугаад л үгээ хэлэх юм чинь тэгээд та нар цуг явчхаж болно. Тэгэхээр үгээ хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгнө үү?

Мөнхтуяа гишүүнээр тасаллаа. Энхтуяа гишүүн асуултаа асууна.

**Д.Энхтуяа:** Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан надад асуулт, үг алга. Энэ Байнгын хорооны үйл ажиллагаатай холбоотой бас үгээ хэлье гээд цаг авчихлаа. Тэгэхээр байнгын хорооны даргаар ХҮН намын гишүүн Ганзориг томилогдсон. Энэ Байнгын хорооны дарга бол маш хариуцлагатай ажил. Энэ бол зөвхөн хуралдаан даргалах биш энэ Байнгын хорооны үйл ажиллагааг хангахдаа гишүүдийн бүх л оролцоог хангах гээд энэ маш хариуцлагатай ажил. Тэгэхээр ер нь бол Байнгын хорооны даргаар сонгогдсоноосоо хойш ер нь Байнгын хороогоо даргалахгүй дандаа ийм орлон, түр орлон гүйцэтгэгчтэй ингээд яваад байна.

Тэгээд энэ хүн бид нарт бас Байнгын хороондоо өвчтэй, чөлөөтэй, гадаад томилолттой, дотоод томилолттой гээд энэ асуудлуудаа бас гаргаж хэлэх хэрэгтэй байна. Дээрээс нь хэрвээ Байнгын хорооныхоо энэ хуралдаж байгаа 7 хоногтоо ганц, хоёр удаа хуралдаж байгаа энэ хуралдаанаа даргалж чадахгүй бол энэ хүн ажлаа өгөх хэрэгтэй гэж ингэж бодож байна. Тэгэхээр ямар шалтгааны улмаас ингээд байнга чөлөөтэй байгаа байдаг юм бэ?

**Л.Энхнасан:** Ойлголоо. Өнөөдөр Ганзориг дарга маань Японд томилолттой учраас, гадаадад томилолттой учраас чөлөө авсан байна. Даргад бол уламжилъя. Эндээ анхааръя. Анхааръя энэ дээр. Тэгээд 3 удаа хурал болсон. Тийм дараа нь үгээ хэлэхгүй юу. Энэ дээр анхааръя. Мөнхтуяа гишүүн үгээ хэлнэ үү.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн сонсгол энэ сонсголыг ахлагчид би өөрийнхөө нэрийг дэвшүүлж байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд бол ингээд амьгүй албат шиг нөхдүүд ээлж дараагаа дараалан ингэж сонгогдоод хийж байгаа юмгүй явдаг. Тийм учраас энэ дээр бол нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нь бол шударга ёсонд нийцнэ гэж үзэж байна. Тийм учраас би энэ сонсгол даргалагчид өөрийнхөө нэрийг дэвшүүлж байна.

**Л.Энхнасан:** Ойлголоо асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу?

Бейсен гишүүнээр тасаллаа. Наранбаяр гишүүн үгээ хэлнэ үү.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Өнөөдөр байнгын хорооны бас хуралдаан хуралдаж бид бас олон асуудлыг шийдэхээр ярилцаж байна. Түрүүнд бас Энхтуяа гишүүний хэлсэн зарчмын шаардлагыг бол ойлгож байна. Гэхдээ ХҮН намын гишүүн Ганзориг Байнгын хороон даргаараа сонгогдсоныхоо дараагаас бол өнөөдрийг хүртэл яг хурлаа өөрийн биеэр удирдсан нь бодитой баримт. Дээр нь нэмээд энэ богино хугацаанд бас Эрхтэн, эд, эсийг шилжүүлэн суулгах тухай хууль, Цусны донорын тухай хуулийг бараг яг энэ байнгын хороогоор хэлэлцүүлж, Улсын Их Хурлын чуулганд оруулж заримыг нь эхний хуулийг бол батлуулчхаад байгаа шүү дээ. Ийм бас үр дүн гаргаж ажиллаж байгаа гэдгийг би бас энд зориуд тэмдэглэн хэлэхийг хүсэж байна.

Ийм учраас бас энэ Байнгын хорооны гишүүд бас өөрсдөө бас хуралдаа сайн сууж ирцдээ орчхоод алга болох биш орж сууж бас ажилдаа идэвхтэй оролцдог байх нь их чухал гэж миний бие бодож байгаа юм.

Энэ нэр дэвшигчийн сонсголын тухайд бол бас зарим тал дээр миний бас харж байхад үнэхээрийн энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг сайн амилуулаад аваад явчих илүү идэвхтэй ажиллачих ийм хүмүүс бас байгаасай гэж хүсэж байгаа. Ийм учраас Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяагаар ахлуулсан энэ сонсголыг бол дэмжиж байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Энэ асуудалтай холбоотой би түрүүн бас Ганзориг даргад албан ёсны албан тоот явуулсан. Яагаад гэвэл эрүүл мэндийн салбарын өглөг, авлагын асуудал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай холбоотой тийшээгээ чихээд байдаг. Тийм учраас энд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, бусад эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлыг сайдын сонсголыг сонсьё бас тэр тухайн байгууллагуудын юу гээд тэгсэн. Тэр бас ороогүй байна. Тэрийг бас дамжуулж хэлээд хэлэлцүүлээд шийдэхгүй бол энэ эрүүл мэндийн салбар босохоо байлаа. Ер нь маш хүнд байна. Энэ талын асуудал дээр бас дамжуулж хэлж өгнө үү.

**Л.Энхнасан:** Ойлголоо. Ер нь манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд бол хамгийн идэвхтэй ирцдээ ордог улс төрждөггүй ийм Байнгын хорооны гишүүд байгаа шүү. Та нартаа талархаж байна. Ингээд санал хураалт тээ. Энэ товлосон өдрөө уншчихсан. Тэгээд нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяаг томилсугай. Энэ тогтоолыг нэр дэвшигчийн сонсголын товыг, тийм санал авна. Харин тийм тэгээд өөр гишүүн байхгүй байгаа юм чинь тогтоолоо саяынхаараа “Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг саяын уншсан нэр томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

23 гишүүн оролцож 17 гишүүн дэмжиж, 73.9 хувиар дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Дараагийн хэлэлцэх асуудалд орёе.

14.46 цаг

**Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028 он, 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийг явуулна.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Ажлын хэсэг танилцуулъя. Ж.Энхбаяр Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, С.Даваасүрэн Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засаг бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга, Райымбек Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга. Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ням-Очир Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Адьяасүрэн Боловсролын Яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Рэнцэнханд Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Отгонбилэг Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Энхтөр Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Урьболд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ариунсанаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Эрүүл мэндийн яамнаас Мөнхцэцэг Санхүү, эдийн засаг, бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Батбаатар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч. Эдгээр хүмүүс ажлын хэсгээс оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэх

бөгөөд хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй гишүүн хуулийн төслийн зүйлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болон төсвийн ерөнхий захирагч нараас асуулт асууж болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Төсвийн хүрээн дээр. Энэ нөгөө төсвийн хүрээтэй хамт өргөн мэдүүлсэн нэмэгдсэн өртгийн албан биш. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028 он, 29 оны төсвийн төсөөллийн тухай гээд. Асуулт асуух гишүүд байна уу?

Мөнхтуяа гишүүнээр, Наранбаяр гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүн асуултаа асууна уу .

**М.Ганхүлэг:** Жоохон нийгмийн хамгааллын асуудал, хүний хөгжлийн асуудал эрхэлсэн Байнгын хороо учраас ирэх төсвийн төсөөлөл дээр, төсвийн орлого дээр нийгмийн даатгалын орлогыг бас хэрхэн төсөөлж байгаа тухай нарийвчилж бас асууя. Нийгмийн даатгалын орлого нь бол бас төсвийн орлогын тогтвортой эх үүсвэр бас байгаа. Тэгэхээр ирэх жилүүдэд ер нь ямар хүрээнд байна гэж тооцоолж байна вэ? Үүнтэй холбогдолтой бас тодорхой иргэддээ бодитоор бас хүрч чадахгүй байгаа олон асуудлууд бас байгаа. Маргаантай асуудлууд бас байгаа. Тэгэхээр энийг бас бас цаашдаа зохицуулахтай холбогдолтой, хүсэлттэй холбогдолтой нарийвчилсан мэдээлэл эхний удаад авъя.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариулах уу? Ажлын хэсгээс яамнаас хэн хариулах юм? 3 дугаар микрофон Санжаа.

**М.Санжаадорж:** Сангийн яамнаас Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга гишүүний асуултад хариулья. Одоо бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол орлогын доод хэмжээг бол бид нар баталж байгаа. Тэгэхдээ тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ. Өөрөөр хэлбэл, Ирээдүй өв сан, Хуримтлалын сангийн бол орлого орохгүйгээр тэнцвэржүүлсэн орлогын төсөв. Энэ дүн бол бөөн дүнгээр бол батлагдаж байгаа. Энэ тоо бол бид нар яаж гаргаж ирж байгаа вэ гэхлээр Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа бүх талаас нь тооцоод нэгдүгээрт, макро эдийн засгийн үзүүлэлтүүд. Хоёрдугаарт, энэ жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй уялдуулж бол гаргаж ирж байгаа.

Нийгмийн даатгалын сангийн бол орлого одоо 6.7 их наяд төгрөг байгаа. Энэ орлогыг ирэх жил зарлага маань бас хэрхэн батлагдахаас шалтгаалаад цалин нэмэгдэх үү үгүй юү гэдгээс бас шалтгаалж байж НДШ-ийн орлого бол тодорхойлно.

Жил болгоны ер нь улсын нийт цалингийн сан бол 30 их наяд байгаа. 30 их наядаас бид нар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг тооцож байгаа. Энэ жилийн хувьд. Ирэх жил дээр бол хэрвээ хувийн, төрийн, төсвийн байгууллагуудын цалинг хэрвээ нэмсэн тохиолдолд бол хувийн хэвшил бол дагаад бас тэн дээр бол нэмэгдэх зүйл бол орж ирнэ. Тэгсэн тохиолдолд дахиад орлого маань бол илүү нарийвчилна гэж байгаа юм. Тэгэхээр намар 9 сарын 1-нд өргөн барихдаа яг орлогоо нэр төрлөөр нь бол гаргаж ирэх юм байгаа юм. Одоо бол багцаагаар бол

бид нар 10 хувийн өсөлттэй байна гэдгээр бол тооцсон байгаа. Тийм НДШ-ийн орлогыг.

**Л.Энхнасан:** Бейсен гишүүн асуултаа асууна.

**Б.Бейсен:** Монгол Улсын нэгдсэн төсвийн 27 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой юм асуух гээд байна. Энэ эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээ бас алдагдаж байна. Энэ нь яагаад гэвэл хотын клиникийн эмнэлгүүд, дүүргийн нэгдсэн эмнэлгүүд, аймгуудын нэгдсэн эмнэлгийн өр зээл, өглөг, авлага бол маш их болсон. Зарим нь 20 хэдэн тэрбум хүрчихсэн. Аймаг дээр 4, 5 тэрбум хүрчихсэн. Тэгэхээр энд чинь эрүүл мэндийн даатгалтай холбоотой биш гээд байх юм. Тэгэхдээ энэ бас байгууллагуудын буруутай үйл ажиллагаа бас байдаг байх. Энийг судалсан уу? Ер нь өглөг, авлага нийтдээ хэр байна? Одоо энийг хааж чадах юм уу нэгдүгээрт?

Хоёрдугаарт, энэ хувийн эмнэлгүүд байж байна. Уул нь 33 л байсан. Одоо 20-оод эмнэлэг байх шиг байх юм. Яг улсын эмнэлэгтэй адилхан Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авчхаад төлбөр өндөр 3 саяас 30 хэдэн сая хүртэл төлбөр авдаг. Гэрээлсэн юуны дагуу хэвтэн эмчлүүлсэн буцаан олголт байдаггүй. Өндөр цалин өгөөд улсын эмнэлгүүдийн чадвартай эмч, сувилагч нарыг авчихдаг. Тэгэхээр энэ асуудлыг яаж шийдэх гэж байна нэгдүгээрт?

Хоёрдугаарт, энэ төсвийн ерөнхийдөө энэ эмнэлгүүдийн төсөвтэй холбоотой бас нэг юм байж байна. Урсгал зардал, эмийн төсөв хасаад хаячихсан. Би бүх аймгуудаас асуулаа эмнэлгүүдээсээ энийг хасаад хаячихсан байх юм. Энийг энэ төсвийн хүрээний 27-ны юун дээр чинь тэр чигээр оруулж ирсэн үү нэмж тусгасан уу энийг? Дараа тодруулъя.

**Л.Энхнасан:** Ажлын хэсгээс Батбаатар дарга хариулах уу? 3 дугаар микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн салбарын манай одоогийн сонгож авсан тогтолцоо маань бол гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо байгаа. Өөрөөр хэлбэл, бид эмнэлэгт ажиллаж байгаа Дорж, Дулмаа гэж эмчийн цалин гэхээсээ илүүтэй Монгол Улсын иргэн Дорж, Дуламааг хэрхэн чанартай эмчилгээ, үйлчилгээ үзүүлсэн үү үгүй юү гэдэг энэ дээр бол санхүүжилтийг олгож явж байгаа. Тэрнээс биш бид нар өмнөх нийгмийн үе шигээ тэнд байгаа бүх эмнэлгүүдээ тоолоод тэр эмнэлэг дээр байгаа ажилчдынх нь цалинг тооцоод явдаг энэ жишгээсээ бол уул нь салчхаад байгаа юм.

Тэгэхлээр яг энэ агуулгаар бол хувийн хэвшлийн эмнэлэг, төрийн эмнэлэг дээр бол яг адилхан тариф бол бид нар мөрдүүлж байгаа Даатгалын сангаас өгөх. Хэрвээ хувийн эмнэлэг өөрөө даатгалын сангаас энэ тарифаар энэ эмчилгээ үйлчилгээг үзүүлье гээд гэрээлэх юм бол нөгөө талдаа иргэнээс та нар төлбөр нэмж авахгүй шүү гэдэг гэрээгээ давхар хийж байгаа. Өөрөөр хэлбэл, авахгүй гэсэн үг. Зарим юу гэдэг юм өндөр төлбөртэй таны хэлж байгаа шиг эмнэлгүүд бол байж байж болно. Энэ эмнэлгүүд бол даатгалтай гэрээ хийхгүй байх эрх нь бас байж байгаа. Өөрөөр хэлбэл, зөвхөн иргэдээсээ тарифаа аваад явах ийм эрх нь бол байж байгаа. Тэгэхээр бол эрүүл мэндийн даатгалаас бол зөвхөн

гүйцэтгэлийнх нь дагуу Дорж, Дулмааг Монгол Улсын иргэнийг эмчилснийх нь төлөө тарифыг нь өгнө.

Харин эмнэлгийн менежментийн асуудал бол тухайн байгууллагынх нь менежмент болчхоод байгаа. Тухайн байгууллага нь өөрөө эрүүл мэндийн байгууллага боловч нөгөө талдаа энэ чинь өөрөө аж ахуйн нэгж байгууллага. Тэгэхлээр орлого бол өөрийнхөө олж байгаа орлоготой нийцүүлж бас зарлагаа гаргах ёстой. Менежментээ хийх ёстой. Хүн, орон тооных нь тооцоог гаргах ёстой. Эмийн нөөцөө гаргах ёстой. Энэ хүрээндээ л ажлаа хийх ёстой. Хэрвээ энийгээ хийж чадахгүй муу менежер байгаад муу менежменттэй байх юм бол өр үүсэж байгаа зүйлүүд байгаа. Энэ дээр бол Эрүүл мэндийн яамнаас бол тусгайлан бол ажлын хэсэг гаргаад ажиллахаар бол төлөвлөж байгаа юм байна лээ. Энэ яг менежмент муутай байгаа эмнэлгүүд дээр менежментийг нь сайжруулах, хугацаатай үүрэг өгөх, тэгээд энэ дээрээ очиж өр төлбөрийг нь яаралтай барагдуулах ийм байдлаар бол ажиллуулж байгаа.

Тэрнээс биш эрүүл мэндийн даатгалаас бол тухайн нэг эмнэлгийг, энэ эмнэлэг зайлуул даа эвий минь ингээд өртэй байгаад байгаа юм нь үүнд хийгээгүй ч гэсэн илүү мөнгө өгье гэдэг байдлаар бол мөнгө санхүүжүүлж огт болохгүй. Энэ бол манай одоогийн хуулиар явж байгаа энэ тогтолцооны эсрэг зүйл болчих гээд байгаа юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Тодруулга Бейсен гишүүн.

**Б.Бейсен:** Санжаа даргаа энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээ, энэ өр зээлтэй холбоотой цалгардаж байгаа асуудал байгаа байхгүй юу. Одоо хэвтэж байгаа өвчтөнүүд гаднаас эм авчирч байна шүү дээ. Тэгэхээр энийг эмийн төсвийг нь хасаа гэсэн урсгал зардал, хөдөөгийн урсгал зардал дотор алсын түргэн тусламжийн бензин, шатахууны юу байдаг байхгүй юу. Үнэхээр хүнд байдалд орсон. Тэгэхээр энийг л асууж байна шүү дээ.

Нөгөө талаараа улсын эмнэлгүүдээ элгээрээ хэвтүүлчхээд хөл дээр нь босохгүй бол хувийн эмнэлэг л хэвтэж байх шаардлага байхгүй гэж бодож байна. Хотын клиникийн том эмнэлгүүд байж байна, дүүргийн эмнэлгүүд эд нарыг босгож ирэхгүй бол улсын эмнэлгийн байдал хүнд байгаа шүү. Энийг яагаад бодохгүй байна.

**Л.Энхнасан:** 3 дугаар микрофон Батбаатар дарга.

**Ц.Батбаатар:** Гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Батбаатар. Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сан бол 2025 онд бол жилийн эцсийн байдлаар бол 198.3 тэрбум төгрөгийн өр төлбөртэй эрүүл мэндийн байгууллагуудад бол өр төлбөртэй гарсан. Эдгээр өр төлбөрийг бол энэ 2026 оны эхний 4 сарын байдлаар бол 100 хувь бүрэн барагдуулж дууссан байгаа. Тэгэхээр одоо Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгүүдэд ямар нэгэн өр төлбөрийн асуудал бол байхгүй.

Нөгөө талдаа эмнэлгүүд маань эм ханган болон эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгч нарт 2021 оноос хойш хуримтлагдсан өр төлбөрийн асуудал бол явдаг. Энэ бидний Эрүүл мэндийн яаман дээр авсан тооцооллоор бол эрүүл мэндийн байгууллагуудад 2026 оны байдлаар бол 100 орчим тэрбум төгрөгийн өр

төлбөрийн асуудал бол үүсчихсэн явж байгаа. Энэнээс үүдээд өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар бол эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэгч нарт эмнэлгийн байгууллагууд өр төлбөрөө өгөхгүйгээс үүдэлтэй эм хангамжийн хэрэгслүүд бол тасалдах ийм эрсдэлүүд бол.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Бейсен гишүүн тодруулга хийе.

**Б.Бейсен:** Сая эрүүл мэндийн салбарын эмч, ажилчдын цалин 30 хувь нэмсэн. Гэтэл илүү цагийн хөлс шөнө дуудагдах, хагалгаанд дуудах тийм асуудлууд гардаг л даа. Зарим чухал тоног төхөөрөмж, инженерүүд ч юм уу мэргэжилтнүүд. Хуучин нэмэгдээгүй цалингаар нь бодоод дахиж авахдаа татварыг нэмэгдсэн цалингаараа суутгаж байгаа юм бэ? Тэр ямар учиртай юм бол?

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Бейсен гишүүн ээ энэ төсвийн хүрээний мэдэгдэл дотор энэ салбарын асуудал ингээд задлаад ярих юм чинь зохистой биш. Хөгжлийн бодлого ороод ирэхээр тэр үед нь та хөндөөрэй. Ер нь эрүүл мэндийн салбар ер нь 27 онд хамгийн их хөрөнгө оруулалт гадаад болон дотоод хөрөнгө оруулалт авч байгаа эрүүл мэнд, боловсролын салбар бол хамгийн өндөр байгаа. Хамгийн өндөр гадаад хэлний ашиглалттай байгаа. Эрүүл мэндийнхээ эмч, сувилагч, багш, энэ салбарын ажилтны цалингийн асуудлыг шийдэгдчихсэн байгаа.

Жишээлбэл, зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эс, эд, эрхтэн шилжүүлж төв барьж байна. Хавдар судлалын үндэсний төв-II баригдана. 17 аймгийн эмнэлгүүдийг 2 дугаар шатлалын түргэн тусламжийн чадавх бүхий ийм том болгож өргөтгөж байгаа ажлууд хийж байна. Дүүргүүдийн эмнэлгийн шинэчлэл явагдаж байна. Аймгуудын яаралтай тусламжийн төв хийгдэж байна. Улсын төсвөөс 333.5 тэрбумд хөрөнгө оруулалт, гадаад зээлээр 154.3, гадаадын тусламжаар.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Микрофон өгнө үү. Сайдын микрофоныг өгнө үү.

**Ж.Энхбаяр:** Бусад салбар орхигдчихоод л байна шүү Бейсен даргаа. Эрүүл мэнд, боловсрол дээр бол манай гишүүд сайн ажилласан. Хамгийн өндөр гадаад зээл, төсвийн хөрөнгө, нийгмийн асуудал шийдэгдсэн. Одоо энэ салбарыг жоохон орхиод бусад чиглэл рүүгээ анхаарахгүй бол бусад салбар дээр жоохон асуудал үүсээд байгаа.

Ер нь Засгийн газрын бодлого бол хүний хөгжлийн анхаарч байгаа. Эрүүл мэнд, боловсрол 2 дээр. Маш сайн хөрөнгө тавьсан, маш сайн нэмсэн. Энэ тал үнэхээр энэ өнгөрсөн 2 жилийн хугацаанд их өндөр ахиц гарч байгаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Бейсен гишүүн маань дандаа бас эрүүл мэндийн салбарын эмч нарын цалин, ажилчны цалинг бол байнга ярьдаг. Эндээ анхаардаг бас гишүүний нэг. Баярлалаа. Ингээд Батнайрамдал гишүүнийг нэмээд өгнө үү асуулт асуухад. Нэмээд. Оруулна уу. Баясгалан гишүүн асуултаа асууна уу.

**Ж.Баясгалан:** Би жил болгон л асуудаг нэг асуултаа асууя. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл 28-аас 29 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд хэрэглээний үнийн өсөлтийг дахиад л 7 хувь,

2028 онд болохлоор 6, 29 онд 6.3 хувь байхаар маш өөдрөгөөр ингээд төсөөлж байгаа. Тэгээд жил болгон ингэж өөдрөгөөр төсөөлөөд энэ маань зөрөөд байдаг. Одоо Үндэсний статистикийн хорооноос 2026 оны 5 сарын 8-ны өдрийн гарсан инфляцын мэдээгээр бол энэ чинь өөрөө 10.1 хувьд хүрчихсэн байгаа шүү дээ. 2 оронтой тоонд хүрчихсэн. Хүнсний бүтээгдэхүүний бүлгийн үнэ бол 3 дугаар сард ... аравны 9 хувиар нэмсэн. 4 дүгээр сард 19.3 хувиар нэмсэн. Тэгээд бусад барааны бүлгийн үнэ ч ялгаагүй өндөр байгаа.

Тэгээд газар тариалангийн сезон эхлэх үеэр бордооны үнийн хүндрэлүүд гарна, эрсдэлүүд ч бий болохоор байна. Энийг ер нь яаж тооцсон бэ? Дэлхийн банк Монголын эдийн засгаар засгийн талаар гаргасан тоймдоо бол бас 2026 оныг бол макро дэлхийн эдийн засгийн макро байдлаас шалтгаалаад инфляц 8.5 хувьд хадгалагдана гэж төсөөллийг хийсэн байгаа. Тэгэхээр Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас гаргаж байгаа энэ инфляцын талаарх төсөөлөл таамаглалыг хэрхэн авч үзсэн бэ? Хэрхэн суусан бэ? Хамаатуулсан уу?

Хоёрдугаарт, 2026 оны 5 дугаар сарын байдлаар 10.1 хувийн инфляц энэ бол түрүүн би хэлсэн энэ оны турш үргэлжлэх магадлалтай байна гэж. Тэгэхээр 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэлд бол инфляцыг 7 хувь байхаар тусгаж өргөн мэдүүлсэн байгаа. Тэгэхээр 2027 оны төсөвт цалин, тэтгэвэр, тэтгэмж 7 хувь нэмэгдэхээр орж ирж байгаа юу? Инфляцтайгаа уялдуулаад жил болгон ярьдаг тээ. Тэтгэврийн хэмжээг ингээд л сая 500 болгоё гээд л гадаа жил гаран жагсаж байна.

Тэгэхээр энэ хүмүүс тэгээд дээр нь та бүхэн дахиад мэдэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маань мөнгө өөрөө дахиад л амьжиргааны доод түвшин 537 мянган төгрөг болчихсон байхад амьжиргааны доод түвшнээс бага байгаа. Тэгэхээр энэ яг тусгай хэрэгцээт иргэдийнхээ энэ асуудлыг яаж шийдэхээр болсон бэ? Амьд явахын тулд ядаж амьжиргааны доод түвшнээсээ илүү орлоготой, илүү цалинтай байх ёстой байна шүү дээ. Тэгээд энэ асуудлыг асуумаар байна. Хоёрхон асуудал байгаа учраас сайхан тодорхой хариулаад өгөөрэй.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариулна уу.

**Ж.Энхбаяр:** 27 он дээр зардал 4 их наядаар нэмэгдэж байгаа. Энэ цалин, тэтгэвэр, энэ халамжийн бодлогууд л хуулиар заасан инфляцтай холбоотой нэмэгдлүүд л орж байгаа. Олон салбарт энэнээс илүү гарнаб Нэг.

Өнгөрсөн 25 оны инфляцын зорилтот түвшин 7.5 гарсан 25 он. 26 оны төсөөлөл бол бид нар 8.8 гэж 26 оныг, 27 оныг байж байгаарай 26 оны 8.8 гэж төсөөлж явж байгаа. Энэ бол Монголбанкны яг зорилтот интервал бол 6 дээр нэмэх нь 2 гээд 8 байхад бол бид нар бол 8.8 гэж төсөөлж байгаа.

Дэлхий нийтийн тулгараад байгаа нийтлэг нэг сорилт бол энэ Ойрх Дорнодтой холбоотой, шатахууны үнийн өсөлттэй холбоотой инфляцын огцом нэмэгдлүүд зайлшгүй болчихоод байгаа. Эхний нөлөө орж ирж байна. Инфляц 4 дүгээр улирлын, 4 дүгээр сарын эцсээр 10.1 хувь руу 2 оронтой тоолуур шилжлээ. Энэний хариу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Шатахууны үнийг тогтворжуулах, нефтийг тасралтгүй байлгах арга хэмжээ, ялангуяа энэ инфляц өөрөө тооцоход 430-аад төрлийн барааны дундаж үнийг тооцож байгаа хэрэглээнд байдаг үндсэн. Үүн дотроо хүнсний бүлэг өндөр нэмэгдэлтэй. Ялангуяа мах,

хүнсний ногоо, гурил, гурилан бүтээгдэхүүний өсөлт өндөр байгаа. Төмс гэхэд л 80 хувь өсөлттэй байх жишээтэй. Энэ бол харьцангуй манай дотоодоосоо бид нар шийдэх бололцоотой үнэ.

Тэгэхээр энэ жил өвөлжилт эвтэйхэн, хаваржилт эвтэйхэн, төл авалт боломжийн. Одоо ингээд нийлүүлэлт нэмэгдээд ирэхээр махны асуудал аажимдаа ингээд шингээд эрс унана. Энэ жил хаврын тариалалт дээр онцгой анхаараад шатахууныхаа өвөл татсан нөөцөөсөө тэр татсан бага үнэтэй үнээсээ бид нар нийлүүлэлт хийсэн. Шатахууныг нь 10 мянган тонноор хангасан. Бордоог мөн өвлийг нь татсан хямд үнэ, ургамал хамгааллын бодис өвлийн татсан нөгөө хямд үнээрээ, хуучин үнээрээ энэ жилийн хаврын тариалалтыг хийсэн. Тэгэхээр энэ дотоодоос үүсээд байгаа энэ ногоо, улаан буудай, гурил, мах гэсэн инфляцууд намар талдаа бол нэлээн тогтворжоод ороод ирнэ гэдэг. Энэ Ойрх Дорнодын асуудал маань 26 ондоо бид нарт бол бодитой бол нэлээн үнийн өсөлтийн дарамт үзүүлнэ.

Дээрээс нь шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор гадаад валют дээр бас нөлөөлж байна. Одоо бид нар чинь сард 250 мянган тонн шатах тос материал авч байгаа бол 200 сая доллар шилжүүлдэг байсан бол энэ чинь 400 сая доллар болоод л илүү мөнгө шилждэг болоод эхэлж байгаа юм. Тэгэхээр гадаад нөөц дээр жоохон дарамт учирна. Тэгэхээр бид нар ханшаа хадгалахын тулд экспортыг нэмэгдүүлэх бодлогуудыг идэвхжүүлж байна. Экспорт талдаа худалдааны хориг, саадыг чөлөөлөх ажлуудыг байнга зохион байгуулж, Эдийн засаг, хөгжлийн яам хариуцаж ажиллаж байна.

Тэгэхээр таны тэр санаа зовниж байгаатай бол яг адилхан. Засгийн газар тэгээд хариу арга хэмжээн дээрээ бид нар ажиллаад энэ Их Хурлын нөгөө төсвийн хүрээг дагуулаад 2 хууль өргөн барьсан. Энэ 2 хуулийг дэмжиж өгөөсэй гэж Их Хурлын гишүүдээсээ хүсэж байгаа. Төсвийн хүрээ 6 сард нь батлагдангуут төсвийн тодотголыг өргөн барья гэж байгаа. Дэлхийн бүх улс орнууд яаралтай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Иймд бид нар төсвийн тодотгол хийхэд заавал 3 сар хүлээх одоогийн хуулийн зохицуулалттай байхгүй юу. 9 сар хүртэл тэр төсвөө тодотгох бололцоогүй.

Тэгэхээрээ 6 сарын 1-ндээ энийгээ төсвийн хүрээгээ батлангуутаа тодотголоо өргөн бариад 6 сардаа төсвөө цэгцлээд энэ өсөлт, үнийн инфляц, хариу арга хэмжээ, энэ цалин, тэтгэврийн зөрүү, хөрөнгө оруулалтын асуудлаа нэг шийдчихвэл их чухал байна. Намар тийшээ 9 сард өргөн барина. Чуулган 10 сараас орж ирнэ, хэлэлцэнэ гэсээр байтал бас хариу арга хэмжээ нь оройтоод үр өгөөж нь нэлээн буучих гээд байгаа юм. Тэгэхээрээ тийм учиртай 2 хууль дагаж яваа.

НӨАТ-ын буцаан олголтыг 20 хувь буцаан олгож байгаа шүү дээ иргэдэд. Энийг 50 хувь болгох.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд гүйцэж хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Нэг ярьсных жоохон дэлгэрэнгүй. Энийг 50 хувь болохыг буцаа гэж байгаа юм. Хэрвээ НӨАТ-ын буцаан олголтыг 50 хувь болгочих юм бол 1.8 их наяд төгрөгийн төсвийн орлого байхгүй болж байгаа юм. Тэгэхээр 1.8 их наяд гэдэг чинь ирэх оны хөрөнгө оруулах бололцоо чинь 2.2 их наяд байгаа

байхгүй юу. 27-нд бид нар шинээр хөрөнгө оруулалт хийж чадахгүй. Үргэлжилж байгаа хөрөнгө оруулалт одоо 3.6 их наядын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хүлээж байгаа. Үүнээс дөнгөж 2.2-ыг санхүүжүүлэх байгаа юм.

Гэтэл энэ НӨАТ-ын буцаан олголтыг 50 хувь болгосноор нөгөө 2.2-оос чинь ахиад 1.8 нь авчих юм бол үргэлжлэх хөрөнгө оруулалтын хууль дээр санхүүжүүлж чадахгүй байдал орно. Тэгэхээр энэ хуулийг бас хэрэгжилтийг нь хойшлуулъя. Хүчингүй болгож өгөөч. гэсэн ийм 2 санал давхар яваад байгаа юм. Үнэхээр энэ шатахууны өсөлт, гадаад орчин бол бидний таамаглаагүй төсөөллийг эвдэж байгаа ийм нөхцөл байдлууд үүсгэж байгаа юм.

**Л.Энхнасан:** Хоёрдугаар асуулт нь гишүүнээ. Яамнаас хариулах уу? Отгонбилэг дарга хариулах уу? 2 дугаар микрофонд суу. Сайд нэмж хариулъя.

**Ж.Энхбаяр:** Засгийн газар яг хуулийн хэрэгжилтийг хангаад л инфляцын хэмжээнд цалин, тэтгэврийн, тэтгэмжийн хэмжээ нэмэгдээд л ороод ирж байгаа юм. Тэрүүгээрээ ороод явна гэдгээрээ. Инфляц гэхдээ ирэх ондоо бид нар 27 оныг ярьж байна шүү дээ энэ шатахууны өсөлт, Ойрх Дорнодын асуудал нь 26 ондоо шийдэгдээд 2 тийшээ болох байх гэж найдаж байна. Тэгээд 27 оноос ердийн юм руу ороод ирэхээр инфляц бол бид нарын тавьж байгаа энэ энэ зорилтот түвшнээ хангаад ингээд явчих байх гэсэн ийм хүлээлттэй байна.

Нөгөө талаасаа дотоодын үйлдвэрлэлд бас 27 оноос их идэвхжилүүд их нэлээн сайн гарна. Нүүрсний экспорт, олборлолт нэмэгдэж байгаа. Оюу толгой дахь зэсийн баяжмалын агуулга нэмэгдэж байна. Төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэж, үнэ тогтвортой байгаа. Зэсийн үнэ өндөр байгаа. Тэгээд ган, зэс нүүрс, пиролиз боловсруулах үйлдвэрүүдийн энэ уул уурхайн боловсруулах үйлдвэрийн ажлууд эхэлнэ. Нөгөө уламжлалт Хүнсний хувьсгал, Атар 4, Цагаан алт хөтөлбөрүүд үргэлжилсэн хэвээр явж байна. Хил холболтуудын төмөр замын ажлууд дуусна. Баян.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Баясгалан гишүүн тодруулга уу тээ?

**Ж.Баясгалан:** Эхнийх дээр бол хангалттай сайн мэдээлэл авлаа. Хоёр дахь дээр тэр дахиад л хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг л яриад байгаа юм л даа. 477 мянган төгрөг авч байгаа одоо сард. Улаанбаатар хотын амьжиргааны доод түвшин 547 мянга тийм ээ. Тэгэхээр 7 хувь нэмээд эд нар чинь 511 мянган төгрөг л авах гээд байна шүү дээ. Дахиад амьжиргааныхаа доод түвшинд хүрэхгүй байна.

Асран халамжлагчид байна 302 мянган төгрөг авч байсан ноднин нэмэгдээд 320 мянган төгрөг болсон. 320 мянган төгрөгтэй хүн 7 хувь нэмэхлээр чинь дахиад нөгөө амьжиргааны доод түвшнийхээ 60 хувь л болж байна шүү дээ. Тэгэхээр яг энэ асуудал дээр яаж хандах юм бэ? Тэгээд энэ халамж гэхлээрээ хавтгайруулж ойлгоод хүн амын бодлоготойгоо цуг ойлгодгоо яг салгаад халамжийг тусад нь гаргаач ээ.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариулна.

**Ж.Энхбаяр:** Баясгалан гишүүний яриад байгаа энэ халамж, тэтгэвэр, тэтгэмж энэ юмыг ялгах гэдэг нь их зүйтэй санаачилга. Тэрийг Засгийн газар бол дэмжиж байгаа. Халамжийн зардлын дээд хэмжээ одоо төсвийн хүрээ чинь ингээд

9 тоо ярина. 9 тооны хамгийн доод талд халамж гэж байдаг. Халамжийн зардлын дээд хэмжээ ДНБ-ий 2.5 буюу 2.8 их наяд төгрөгийн зардал халамжийн зардал явна. Энэ нь энэ оны зардлаас 100 гаруй тэрбумаар нэмэгдэж явж байгаа. Ингээд бид нар дээд нөгөө зардлын хэмжээг нь батлаад өгч байгаа юм одоо. Энэ яг энэ задалчихсан дээр Сангийн яам чинь төсвөө зохионо. Бид бол улсын орлого энэ байна, зардал энэ байна, суурь тэнцэл чинь ийм байна, Засгийн газрын өр энэ хэмжээнд та нар өр авч болно, өрийг ингэж зохицуулна, инфляц ийм юм явах нь байна, эдийн засгаа ингэж өсгөнө гээд ер нь бүх тоо нөгөө хүрээг нь гаргаад өгч байгаа юм. Энэ дээрээ Сангийн яам чинь зун ажиллаад төсвөө зохионо шүү дээ. Тэгээд тэр төсөв зохиох хүрээнд таны асуудаг яг деталь хөдөлмөр хөлсний доод хэмжээ, нөгөө.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Тодруулга Баясгалан гишүүн.

**Ж.Баясгалан:** Энийг тодруулга гэхээс илүү яг түрүүн таны хэлснээр тэмдэглүүлж үлдээх гээд байгаа. 2.8 буюу 2 тэрбум, 2 их наяд 823 сая. Тэгвэл энэний 70 хувь нь энэ хүн ам зүйн бодлогод чиглэсэн мөнгө байгаа шүү дээ. Халамж биш. Халамжид чиглэсэн нь ердөө 600 тэрбум төгрөг байгаа шүү. Энэ 70 хувь нь болохлоор нөгөө хүүхдийн мөнгөн тэтгэмж байдаг. 0-3 насны хүүхдээ асарсны тэтгэмж, жирэмсэн эхийн тэтгэмж, хүүхдэд чиглэсэн үйлчилгээнүүд байдаг юм. Тэгэхээр энэ дээрээ та хэд яг нарийн сайн салгаад. Би өмнө нь бас чуулган дээр хэлсэн. Энийгээ салгаад тэр 600 тэрбум төгрөг яг халамж хэрэгтэй байгаа хүнд хэлбэрийн асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настандаа зориулсан тэр мөнгөн дээрээ сайн бодлого гаргаарай. Тэгэхгүй бол энэ чинь амьжиргааны доод түвшнээс доор ядуурлын бүүр доод цэгт хүрч байна шүү дээ. Энийг бүүр анхааралдаа аваарай гэж эхнээс нь хэлж байгаа юм шүү.

**Л.Энхнасан:** Яам бас Халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулга оруулж ирнэ гээд бараг 2 жил ярьж байгаа. Энэ хуулиа бас одоо яаралтай оруулж ирэх хэрэгтэй байна. Тэгээд энэ дээр бас анхаараарай. Батнайрамдал гишүүн асуултаа асууна уу.

**О.Батнайрамдал:** Монгол Улсын Нэгдсэн төсвийн 27 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 28-аас 29 оны төсвийн төсөөлөл. Тэгэхээр энэ маш ойлгомжтойгоор бол ерөөсөө бид нар дараагийн 3 жилдээ ерөнхийдөө ямархуу төлөвтэй эдийн засгийн өсөлтийг авчрах юм, төсөв нь яг хүрээ хязгаар нь хаана байх юм гэдгээ л батална гэсэн үг юм. Тэгэхээр 3 жилийн зураглалаа гаргаж байгаа энэ Засгийн газраас өргөн барьсан төслийг бол Энхбаяр сайдаа дэмжиж байгаа, дэмжиж байгаа. Ер нь энэ дотор байгаа 9 тоонууд бол боломжийн хүрчих болов уу гэсэн инфляцаас бусад нь бол болчих болов уу гэж бодож байгаа юм.

Энэ хуулийг бас дагаад тэр миний зарчмын хувьд бас асуух гээд байгаа нь энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орж байгаа өөрчлөлт юм л даа. Ер нь дунд хугацааны тодорхойлолтоо гаргаж байхад бол энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бол энэ уул нь дагал дангаар орж ирэх хууль биш юм. Энэ бол уул нь бол уг нь энэ дунд хугацааныхаа бодлогынхоо дээвэр дээр нь байх тогтвортой байдлыг урт хугацаандаа хангах тухай хууль шүү дээ тээ?

Тэгэхээр яах вэ энэ хуулийн 7.5-д энэ өөрчлөлт юу вэ гэхээрээ 3, энэ дунд хугацааны бид нар 2029 он хүртэл зураглалаа тодорхойлоход тодорхойлчихоод 3 сарын дотор аваачаад ямар нэгэн өөрчлөлт хийхгүй шүү л гэдэг зарчмын

шаардлага байхгүй юу. Маш энгийн ер нь бол зөв зарчим. Тийм зөв зарчим. Гэхдээ яах вэ энэ удаа би ойлгож байна. Засгийн газар дөнгөж эмхлэн байгуулагдаад 2 сарын хугацаа бас болоогүй байна. 2026 оны эхний улирлын гүйцэтгэлээр 1.4 их наядын алдагдалтай төсөвтэй, ийм гүйцэтгэлтэй явж байгаа.

Тэгэхээр энэ удаадаа бол одоо төсвөө дахин тодотгох боломжийг бол олгох ёстой гэж хувьдаа бол бодож байгаа юм. Тийм болохоор энэ хуулийн дагаж орж ирж байгаа өөрчлөлтийг нөхцөлтэйгөөр дэмжмээр байгаа юм. Тэр нь юу вэ гэхээрээ энэ удаадаа явуулчихъя.

Гэхдээ төсөв тодотгосны дараа буцааж энэ хуулийнхаа зарчмыг миний хувьд бол би өөрөө энийг санаачлаад энэ хуулийг буцааж батлуулна. Энэ яагаад гэх юм бол 1 удаагийн жишээгээрээ буцаад төсвийн тогтвортой байдлынхаа энэ зарчмаа алдаж болохгүй байхгүй юу. Энэ бол урт хугацаандаа хэрэгжээд явах, бидний барих ёсондоо үндсэн зарчмуудыг Төсвийн тогтвортой байдлын хуульдаа бид нар зоож өгдөг тийм үү? Тэгэхээр энэ удаагийн төсвийн тодотголоо явуулаад тэрний дараа бол энэ дагаж орж ирж байгаа хуулийг бол би буцаад зарчмын хувьд хассаныг нь буцаж нэмж орж ирүүлэх ийм нөхцөлтэйгөөр бол энэ удаагийн төсвийн тогтвортой байдлын энэ Төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн төсөөллийн тухай хууль болон дагалдаж ирж байгаа хуулиудыг бол дэмжье гэж бодож байгаа юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Энхбаяр гишүүн хариулъя.

**Ж.Энхбаяр:** Таны саналыг ойлголоо. Үнэхээр урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдал үүсээд байгаа юм. Урсгал зардлын сайн өсөлт, шатахуунаар дамжиж инфляцын өсөлт, тэгээд төсвийн тэнцэл өнөөдөр 1.4 их наядын алдагдалд орж эхэлж байгаа энэ цаг үед бид нар яаралтай хариу арга хэмжээг авах ёстой. Одоо байгаа хуулиар бол 6 сарын 1 гэхэд бид нар энэ төсвийн хүрээгээ батлаад тэгээд дараагийн хэлэлцэх эрх нь 9 сарын 1-нд үүснэ гэсэн үг. 3 сарын дараа нээгдэж байгаа юм. Тэгэх хугацаанд бид нар энэ дунд хугацаанд энэ 6, 7, 8 сард 9 сард инфляц нэлээн өндөр, сөрөг нөлөөллүүд их гарна.

Тэрийг аль болох хохирол багатай даван туулахын тулд Засгийн газар төсөвтөө тодотгол хийгээд шуурхай хариу арга хэмжээ авах шаардлага үүсээд байгаа юм. Тэр талаасаа л бид нар энэ тодотголоо 6 сардаа өргөн бариад энэ хаврын чуулгандаа багтаад наадмаас өмнө бүгдээрээ төсвөө шинэчилчхээд эндэх юмаа цэгцэлчхээд явчихвал хаа хаанаа бүгдээрээ хэрэгтэй юм болов уу гэсэн ийм санал.

Үүгээрээ цалин, тэтгэврээ ч цэгцэлье, хөрөнгө оруулалтаа ч цэгцэлчихье, урсгал зардал дээрээ ч байр сууриа ойлгомжтой болгочихвол их хэрэгтэй юм. Заавал 10 сарыг 9 сард өргөн барина. Тэгээд 10 сар гэсээр байтал оны төгсгөл рүү шахаад энэ хугацаанд чинь урсгал зардал баахан явчихна. Хөрөнгө оруулалтууд баахан явчихна. Тэгээд нөгөө хэрэгждэггүй дутуу баахан гүйцэтгэлүүд үүсээд, жилийн эцэст баахан өр, авлага, нөгөө цалин тэтгэврийн ачаалал чинь үүсчих вий гэдэг нь тийм эрсдэл нь бодитой байгаа юм.

Тэгэхээр энийг энийг та бүхэн маань ойлгоод бүгдээрээ 1 удаагийн арга хэмжээ олгоод гэдэг дээр бол би бол санал нэг байгаа. Ер нь хууль маань өөрөө төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах гэж хийсэн зүйл шүү дээ. Гэтэл

дайн дажин, гадаад, дотоод гэнэтийн нөлөөлөл, гамшиг хямрал ийм үед бол бид нар их Засгийн газарт аль болох хурдан ажиллах, маневрлах орон зайг нь гаргаж өгөөд тэгээд ажлаа сайн гээд хийе гэдэг нь бол их зүйтэй юм болов уу л гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр тэр инфляц 7 хувь, эдийн засгийн өсөлт 5.8 гэдэг чинь манай зорилт байхгүй юу. Тэгэхээрээ засаг бол энэний төлөө бид нар хангахын төлөө л явна. Тэрнээс бага оруулж ирээд зорилтоо бага болгох шиг амархан юм байхгүй шүү дээ. Тэгж болохгүй. Дандаа зорилт тавина. Энэ чинь гадаадад бас том бас мессеж болно. Монгол улс ингэж эдийн засгийн өсөлттэй тооцоолж байгаа юм байна, ийм хөрөнгө оруулалт төсөв зарцуулж байгаа юм байна гээд энэний чинь гадаад бас зах зээлийг их сайн нөлөөнүүд, мессежнүүд болж хувирдаг.

Тийм болохоор бид бас засаг жоохон өөдрөг тавьдаг. Тэгээд сүүлийн 4 жилийн хугацааг харахад бид нарын тавьсан төсөөлөл өөдрөг төсөөлөл бүгд л хэрэгжсэн байгаа. Дандаа амжилттай хэрэгжүүлээд л хүрч чад чадаад байгаа. Тэгэхээр энэ 27 ондоо бол яг энэ тавьсан зорилтыг хэрэгжүүлж чадна. 26 онд харин яаралтай ийм гэнэтийн ийм зайлшгүй ийм нөхцөл байдал урьдчилан тооцох бололцоогүй ийм зүйл үүсчхээд энэ чинь дэлхий нийтээрээ л бид нар сандраад, Засгийн газрууд арга хэмжээ аваад их хурдтай л ажиллаад байна. Тэгэхээр бидэнд тийм энэ дагасан 2 хуулийг нь дэмжиж өгөөд төсөвт тодотгол хийх бололцоог олгоод өгвөл бас их сайн байна л гэж.

**Л.Энхнасан:** Батнайрамдал гишүүн тодруулга хийнэ. Батнайрамдал гишүүний.

**О.Батнайрамдал:** Тэгэхээр угаасаа төсөв энэ 6, 7 сардаа багтааж тодотгох дээр бол зарчмын хувьд санал нэгдэж байгаа учраас энэ удаа ингээд явуулах дээр нь дэмжинэ. Гэхдээ бас нэг зүйлийг бид нар бүгдээрээ ойлгох ёстой. Гадаад геополитик болоод тэрнээс болоод бид нар төсвийн тогтвортой байдлын хуулиа өөрчилж байгаа гэж бас яримааргүй байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд бид нарын улс төрийн тогтворгүй байдлаас болоод энэ 3-хан сар чинь уул нь богинохон хугацаа шүү дээ.

Тэгэхээр энэ 3 сардаа бид нар багтахгүй л байгаа байхгүй юу үнэндээ бол тээ. Тийм учраас заавал эдийн засаг руугаа оруулмааргүй байгаа юм. Бид нар сүүлийн 3 хугацаанд хэчнээн засаг солигддог юм. Энэнээсээ болоод энэ 3 сар чинь багтахгүй болчхоод байгаа шүү дээ. Тэрнээс хойш 3 сар гэдэг бол их тийм урт хугацаа, богино хугацаа ерөөсөө биш ээ.

Ер нь цаашдаа ингэх ёстой юм байна. Төсвийн тогтворгүй байдлын энэ тогтвортой байдлын тухай хуулийг аль нэгэн дагалдах хуулиар оруулж ирэх нь бол зарчмын хувьд бол буруу гэж бодож байна. Энэ дээр үнэхээр орж ирж өөрчлөх ёстой бол энийг тусад нь өргөн барих ёстой. Хуулийн дагалдангаар аваачаад.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Гүйцээж хэлнэ үү Батнайрамдал гишүүн.

**О.Батнайрамдал:** Ер нь ер нь цаашдаа зарчмын хувьд бол энэ Төсвийн тогтворгүй байдлын тухай хууль бол энэ чухал байхгүй юу. Яагаад гэх юм бол Монгол шиг уул уурхайгаас хэт хамааралтай, уул уурхайн циклээс хамааралтай

эдийн засгийн савлагаанд биднийг үндсэндээ аврах зүйл чинь явж явж энэ төсөв Төсвийн тогтвортой байдлын тухай хууль байхгүй юу. Тэгэхээр энэ хуулийг ер нь цаашдаа Засгийн газраас ч бай ер нь бид нар хаанаас ч бай өөрчлөх юм бол тусад нь өргөн барьж ж өөрчлөх ийм горим руу шилжих хэрэгтэй. Ямар нэгэн хуулийг дагуулж биш. Хуулийг дагуулж байгаа бол буцаад жижигхэн асуудлаа хөндөгдөж байгаад том гогцоогоо чагталдаг ийм л бид нар юм руу яваад байна л даа.

Тэгэхээр энэ хууль дээр ч гэсэн ер нь олон өөрчлөлт орох нь бол ингээд буцаад л эдийн засгаа савлуулах үндсэн бас нөхцөл л ингээд цаашдаа болдог. Тийм учраас яг энэ хууль төсөв тодотгосны дараа энэ хуулийг буцааж өргөн барина. Буцааж өргөн барихдаа бас шаардлагатай ганц нэг засвар орох ёстой юм байна гэж ер нь бол харж байгаа юм. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Саранчулуун гишүүн, Хэрлэн гишүүн гадаад уулзалттай байсан учраас сая орж ирлээ. Нэрийг нь нэмээд өгнө үү. Ингээд Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууна уу.

**М.Нарантуяа-Нара:** Өдрийн мэнд хүргэе. Төсвийн асуудал дээр нэгдүгээр асуудлын 3, 4 асуулт асууя. Нэгдүгээр асуудал Засгийн газрын нийт өрийн хэмжээ 2027 онд 57 их наяд байна гээд орж ирж байна. Яг одоо Засгийн газрын өр өнөөдрийн байдлаар нийт хэдэн их наяд байна вэ? Үүнээс Монгол Улсын иргэн бүрд ноогдож байгаа нийт өрийн хэмжээ жишээлбэл Нарантуяа-Нарогийн хүүхдэд нь, ингээд бид нарт ер нь 1 иргэнд хэдэн төгрөгийн гадаад өр байна вэ гэдэг асуудал.

Хоёрдугаарт, хоёрдугаарт биш, тэгээд ер нь энэ ДНБ өсөх хэрээр Засгийн газрын өр ингээд тэлсэн байдалтай яваад байх нь зөв үү гэдэг ийм асуултыг асууя.

Хоёрдугаарт нь энэ Нийгмийн халамжийн тухай хуульд заасан дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээг 2.8 их наядад барина гэсэн байна. Ингэхдээ энэ хүүхдийн мөнгө, халамжийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэх шинэчлэл хийх юм уу? Энэ дотор жишээлбэл яг ахмадуудын шаардаад байгаа хэдэн сар гаран энэ хүйтнээс авхуулаад халуун хүртэл гадаа жагсаж байгаа 1.5 сая төгрөг болгох энэ тэтгэврийн асуудлыг багтааж шигтгэж өгч чадсан уу?

Хоёрдугаарт, энд хүүхдийн мөнгөнөөс гадна цалинтай ээжийн хөтөлбөрийг та нар дахин авч хэлэлцэж төсөөлөлдөө оруулсан уу? Жишээлбэл цалинтай ээжийг Үүрийнтуяа гишүүн гэхэд 500 мянган төгрөг болгох боломжтой гэж ийм юм ярьж байсан. Одоо бол байхгүй болчихсон байгаа.

Миний хувьд бол энэ цалинтай ээжийн та бүхэн бол энийг бүүр аягүй сайн тусгаад аваасай гэж бодож байна. Цалинтай ээж хөтөлбөрийн нэршлийг нь нэгдүгээрт болиод ээжийн дэмжлэг ч юм уу ямар нэгэн юм хэлээд тэгээд цалин гэж тодотгохоо болиод энийг 50 мянган төгрөг өнөөдөр үнэ инфляцын хувьд ямар байгаа билээ тээ. Тэгэхээр 50 мянган төгрөг энэ өөрөө ээжийн хувьд ямар дэмжлэг болж чадах вэ гэдгийг харгалзаж үзээд ядаж 100 мянган төгрөг болгох хэмжээнд та бүхэн бас оруулж ирвэл их сайн байна гэж харж байна.

Одоо Засгийн газар чинь халамжаас хөдөлмөрт гээд л бодлого юу яагаад байгаа шүү дээ. Гэтэл энэ чинь ингээд жил болгон халамжийн зардал ингээд өсөөд

яваад байна. Тэгээд энэнтэй чинь бас хэр дүйцэж байгаа юм бэ гэдэг асуудлыг асууя.

Мөн түүнчлэн энэ Ерөнхий сайд хувь хүний орлогын албан татварын босгыг нь 400 сая хүргэнэ гээд ингээд яриад байгаа. Хэрвээ ийм юм болох юм бол та хэдийн энэ хараад байгаа дунд хугацаанд хувь хүний орлогын албан татварын орлого дунджаар дунджаар 12.8 хувиар өсөхөөр төсөөлж байгаа энэ төсөөлөлтэй чинь бас яаж дүйх бол гэдэг ийм асуудлуудыг асуухаас гадна та түрүүн хэлж байсан эрүүл мэнд, боловсролын салбарт хамгийн их төсөв хуваарилагдаж байгаа гэж яасан. Энэ эрүүл мэнд, боловсролын салбарын санхүүжилтийн үр дүнг яг ер нь яг ямар шалгуураар хэмжих юм?

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Монгол улс нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх таван жилийн хөгжлийн хөтөлбөр байгаа 26, 30. Тэр дотор бүх салбар хэмжих нэгжтэйгээ, шалгах шалгуур үзүүлэлттэйгээ бүүр ингээд дэлгэрэнгүй задалчихсан байгаа. Тэрийг Мөнгөнсүх. өгөөдөх. Тэр бас 27 оны хөгжлийн хөтөлбөр, бодлого дээр бас ахиад яригдана. Тэр үед нь дэлгэрэнгүй танд мэдээлэл өгөөд ярья.

Нийт өрийн асуудал тийм биз? Засгийн газрын өрийн дээд хязгаарыг дотоодын бүтээгдэхүүн 60 хувиас хэтрүүлэхгүй байна гэж заасан байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад. Бид болохоор 27, 28, 29 онуудад 50 хувь, 45 хувь, 50-аас 45 болгож бууруулна гэсэн зорилттой. Одоо болохоор яг одоо энэ жилийн байдлаар бид 39 байна уу, 39.3 хувьтай байгаа. 39 хувьтай буюу 35.4 их наяд төгрөгийн Засгийн газрын гадаад өр байна гэж.

Нөгөө талдаа тэтгэвэр бол халамж биш шүү дээ. Тэтгэврийн хэмжээг хуулийн дагуу инфляцын хэмжээтэй уялдуулаад л нэмээд байгаад байна. Тэр бүх хөрөнгө нь ирэх жилийн төлөвлөгөөндөө сууж байгаа. Ирэх жил 3 жил бид нар энэ гадаад зээлийн ашиглалтыг жоохон нэмэгдүүлье гэж байгаа юм.

Тэгэхээр одоо төсөв алдагдалтай гээд ороод ирлээ шүү дээ. Тэнцвэржүүлсэн орлого чинь 34.7 их наяд, нийт зардал нь 36.4, орлого зарлагаасаа 1.5 хувийн алдагдалтай буюу 1.7 их наядын алдагдал үүсэж байгаа юм. Энийгээ бид нар гадаад зээл авч зарцуулна гэсэн үг. Энэ гадаад зээлээрээ бид нар нөгөө нийгмийн шинж чанартай, орон нутгийн, дэд бүтцийн энэ бусад салбарын хөрөнгө оруулалтуудыг гадаад зээлээрээ. Нэгэнт улсын төсвийн хөрөнгө оруулалт хийх чадавх маань ингээд хязгаарлагдчихаж байгаа юм. Орлого, зарлага дээрээ.

Тэгэхээрээ 27 онд шинэ хөрөнгө оруулалт байхгүй. Гадаад зээлийн ашиглалтаар шинэ хөрөнгө оруулалт буюу нэгэнт нөгөө эрэмбэлэгдсэн олон 18 их наядын гадаад зээл бид нар чинь бүтээчихсэн байхгүй юу. Гэрээ, хэлцэл амлуулчихсан. Ашигладаг хэмжээ маань бас хуулиар хязгаартай. Тэгэхээр тэнд талаасаа ашиглах юмнуудаа нэлээн нэмэгдүүлэх юм. Гадаад зээлийн ашиглалтын хуулийг Засгаас ахиад өргөн барьчихсан. 2 том төслөө гаргачих юм бол гадаад зээлийн ашиглалт дээр бид нар 4 их наяд гаруй гадаад зээлээр бид нар төсөл, хөтөлбөрүүдээ, орон нутгийн, нийгмийн энэ салбарын асуудлуудыг шийдэх бололцоо үүсэх юм.

Тэгэхээр гадаад зээлийг ашиглах нь яг энэ цаг үед их чухал. Гадаад валютаа оруулж ирнэ, дотооддоо шинэ эдийн засгаа идэвхжүүлэхэд их зөв бодлогын үүднээс ингэж хийж байсан. Өөр ч юу байлаа. Тэр Сангийн яамныхан, нийгмийн хамгаалал 2 яриадхаарай.

**Л.Энхнасан:** Санжаадорж дарга 3 дугаар микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол 2027 онд бол бид нар төсвийн хэрэгцээ, шаардлага гэдэг талаас нь харах юм бол 4-6.7 их наядын хэрэгцээ, шаардлага байгаа юм. Энэ дээр бол зөвхөн саяын тэр багш, эмч нарын бол цалингийн асуудал тэгээд тэтгэврийг 10 хувиар магадгүй нэмэх асуудал, эрчим хүчний үнэ тарифын асуудал, тэгээд хүн ам зүйн статистик өөрчлөлттэй холбоотой зардлууд л орж байгаа юм. Тэтгэврийн насныхан болон сурагчдын өсөлт гэсэн үг.

Ингээд үзэхлээр ийм хэрэгцээ шаардлагатай. Одоо бид нарын өргөн барьчихсан байгаа хүрээ маань бол гэхдээ нийт зарлага маань бол 3.5 их наяд дээр өсчихсөн. Үүнээсээ суурь зарлага маань 2.6 их наядаар л өсөж байгаа. Суурь зарлага гэдэг маань одоо бид нарын урсгал цалин хөлс болон хөрөнгийн зардал л нэмж байгаа. Тэгэхээр энэ 2.6-даа багтаагаад л намар төсвөө бол оруулж ирнэ. Тэгэхээр төсөв дотроо бид нар одоо дотор нь зохион байгуулалт хийх ямар боломж байна, энэ дүндээ яаж багтаах боломж байна гэдэг агуулгаар нь орж ирнэ. Ер нь том агуулгаараа бол энэ хүний хөгжлийн бодлогыг бол халамж.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Нэмж хариулна уу. Санжаадорж дарга гүйцээгээд хариулна уу. Тэгээд дараа нь.

**М.Санжаадорж:** Баярлалаа. Тэгэхээр бол бид бол энэ 2.6 дотроо л ярина. Гэхдээ мэдээж хэрэг зарлагын хэрэгцээ шаардлага 4-6.7 их наяд байлаа гээд бид нар хий орлогоо тавьж, төсөвлөж болохгүй. Ингэх юм бол энэ маань өөрөө дахиад дараачийн төсвийн тогтворгүй байдлын зүйл болно. Тэгэхээр бол зарлагадаа бол нэг талдаа бол бид нар хэрэгцээ, шаардлагаа гаргаж байгаа боловч нөгөө талдаа орлогодоо хөтлөгдөж л зарлагаа тавина. Тэгэхээр 2.6 их наяд зарлага цалин хөлс болон урсгал зардлаа бол нэмэх энэ орон зайгаа бол бид нар бол ашиглаад, зөв ашиглаад л явах ёстой гэдэг байдал дээр бол Засгийн газар дээр бол яригдсан байгаа.

Хэрэвзээ түрүүний ярьж байсан жишээ нь тэр НӨАТ-ын хуулийг бол хамтад нь өргөн мэдүүлчихсэн байгаа. Энэ хуулийг Их Хурал дээр бол батлагдаагүй тохиолдолд бол энэ орон зай маань дахиад доошоо буугаад ирэх жил зарлага нэмэх орон зай маань 800 тэрбумаас 1 их наядын л орон зай гарч ирнэ гэсэн үг. Тэгсэн тохиолдолд бол одоо нөгөө багш, эмч нарын цалин нэмэх гээд амлалт авчихсан байгаа.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд нэмж хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Эдийн засаг, хөгжлийн яам чинь төсвийн хүрээ гэдгээрээ яг эдийн засгийн чадавхаа, орлогоо, зарлагыг нь тодорхойлоод өгчхөж байгаа юм. Тэгэхээр Сангийн яам дур зоргоороо орлого нэмж болохгүй, зардал нэмж яг тэр хуулийн хүрээг нь захирах энэ дотор явна л гэдгийг нь заачхаж байгаа юм.

Гадаад зээл дээр Засгийн газрын өртэй холбоотой манай Засгийн газар бүх цаг хугацаанд бүх өрөө цаг хугацаанд нь төлж ирсэн. Ямар нэгэн өр төлөхгүй, хугацаа хойшилсон зүйл байхгүй. Манай зээлжих зэрэглэл тэрийгээ дагаад их өндөр их сайн байгаа. Монгол Улсын зээлжих зэрэглэл гадаад эх үүсвэр татах орон зай их сайтай. Муу биш байгаа шүү. Энэ бол гадаад өр бол ачаалал үүсээд л тулаад байгаа юм байхгүй. Нийт 60 хувь хуулиар байгаагаас бид нар 39 хувьтай л явж байна гэсэн үг.

Дээрээс нь энэ 25 оны жилийн эцсээр нийт 2.4 их наяд төгрөг Нийгмийн халамжийн сангаас энэ “Цалинтай ээж” энэ хөтөлбөрт зарцуулсан. 1.5 нь хүүхдийн мөнгө. Тэгэхээр их өндөр явж байгаа. Тэгээд энэ зардлынх нь 63 хувь нь бол нөгөө нийтлэг мөнгө.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Тодруулга уу? Тодруулга Нарантуяа-Нара.

**М.Нарантуяа-Нара:** Ойлголоо. Тэгэхээр яг одоогийн, өнөөгийн байдлаар бол Засгийн газрын өр 1 хүнд, 1 иргэнд ноогдох өрийн хэмжээ 9.7 сая орчим байна гэж, яах вэ ер нь бол тээ тийм байна. Тэгээд хамгийн гол нь одоо бас энэ Сангийн яамны хэлсэн үгэн дээр бас зүйл энэ хольчихов уу яачхав гэж бодож байна? Яагаад гэвэл энэ 2.8 их наяд чинь энэ чинь бол нийгмийн халамжид хуваарилах төсвийн дээд хэмжээ байгаа шүү дээ. Гэтэл эндээс дахиад багш, ахмадын цалинг амласан амлалтаараа олгоно гэххэв үү, эс үгүй бол би буруу ойлгочхов уу? Нэг асуудал нь хамгийн гол нь энэ жишээлбэл яг энэ 2.8 их наядыг яг энэ энэ зорилтот бүлэг рүү чиглүүлэх ийм шинэчлэлийн хүрээнд оруулж ирж байгаа юу гэдэг асуудал байсан юм шүү дээ.

**Л.Энхнасан:** Санжаадорж дарга 3 дугаар микрофон. Дараа нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Отгонбилэг энэ юун дээр индэр дээр гараад хариулчхаарай.

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Одоо батлах Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бол 9 тоо байгаа. Энэ дотор бол төсвийн нийт зарлагын хэмжээ гэж тоо байгаа. Энэ зарлагын хэмжээ маань 32980 буюу 32 их наяд 980 тэрбумаас 36 их наяд 493 гэж өсөж байгаа. Энэ 3.5 их наядаар өсөж байгаа юм.

Дараа нь болохлоороо суурь зарлагын хэмжээ гэж байгаа. Энэ суурь зарлага гэдэг маань бол цалин хөлс, урсгал зардал дээр нь нэмээд хөрөнгө оруулалтын зардал маань орсон зардал юм. Энэ болохлоороо 29.8 их наядаас 32.4 их наяд буюу 2.6 их наядаар өсөж байгаа юм. Нийт зарлага маань өсөж байгаа нь тэр байхгүй юу. Тэр 2.6 их наядын өсөлт дотроо бид нар жил болгон тэтгэврээ инфляцын хувиар болон нэмэгдүүлнэ гэдэг ийм хуультай.

Дээрээс нь хүүхдийн тооны өсөлт, ахмадын тооны өсөлт гээд бүх статистик өөрчлөлттэй холбоотой энэ өөрчлөлтүүд байгаа. Энэ бүх зүйлүүдээ авах ёстой. Дээрээс нь энэ боловсрол, эрүүл мэнд дээр энэ жилийн нөгөө цалин нэмсэн маань ирэх жил дээр дахиад ачаалал үүсэхээр бол тэрийг тусгах ёстой.

**Л.Энхнасан:** Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Битгий дараарай.

**Ю.Отгонбилэг:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Отгонбилэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Нийгмийн халамжийн сан буюу энэ 2 их наяд 823 тэрбум төгрөг бол 6 хуулийн хүрээнд үйлчилж байгаа үйлчилгээнд зарцуулж байгаа. Нийгмийн халамжийн тухай хууль, Эх эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль, Ахмад настны хөнгөлөлт, Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний ч гэдэг юм уу ингээд энэ бүх хуулиудын хүрээнд ингэж нийтдээ зарцуулагдах үнийн дүн байгаа юм.

Тэгэхээр яг 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж бол энэ дотор орчихсон явж байгаа гэсэн үг. Тэгээд түрүүн Сангийн яам хэлсэн. Ерөнхийдөө бол 2026 оны төсвөөс энэ 2027 оны энэ хүрээний мэдэгдэл бол 190.8 тэрбум төгрөгөөр нэмж төсөвлөсөн байгаа. Тэгээд энэ бүх зардалдаа бол багтааж энэ ирэх оны төсвийг зарцуулах юм байгаа юм. Халам.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Гүйцээж хариулна уу.

**Ю.Отгонбилэг:** Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслүүдийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулчихсан. Засгийн газрын гишүүдээс ингээд санал авах энэ явц явж байгаа. Тэгээд энийг бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд Их Хуралд өргөн барьсны дараагаар энэ халамжийг илүү ингэж зорилтот хэсэгтээ чиглүүлэх, хүүхэд, хүн амын өсөлттэй холбоотой зардлыг ингээд салгах энэ зохицуулалтууд хийгдэх юм байгаа юм.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Хэрлэн гишүүн асуултаа асууна уу.

**Б.Хэрлэн:** Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр би энэ төлөвлөгөө болоод, 27 оны төлөвлөгөө болоод 27 оны төсвийн төсөөлөлтэй холбогдуулаад асуулт асууя. Тэгэхээр энэ төлөвлөгөө дотор бичсэн байгаад байна л даа ер нь бол хүн амын өсөлт сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн доод хэмжээндээ хүрээд байна гэж. Тэгээд ер нь бол хүн амын өсөлт 2 хувьтай байхад бол хэвийн гэж үздэг.

Одоо яг 2025 оны байдлаар хүн амын өсөлт 1 хувьтай болчихоод байгаа. Тэгээд энэ хүн амын өсөлт ингэж буурч байгаад нөлөөлж байгаа их олон хүчин зүйлийн нэг нь бол гэр бүл салалтын тухай асуудал байгаа байх. Энэ гэр бүлийн салалт нь ч гэсэн бас 20 онтой харьцуулах юм бол 21 онд 2.1 промил болж өссөн гээд. Тэгээд гэр бүл салахад нөлөөлж байгаа хамгийн гол хүчин зүйл бол гэр бүлийн өрхийн орлого энэтэй холбоотой байгаад байгаа. Энэтэй холбогдуулж би Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болоод Сангийн яам бас Эдийн засгийн хөгжлийн яамд хандаж 2 асуулт асуух гээд байгаа юм.

Тэгэхээр нэгдүгээрх нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ер нь гэр бүлийг дэмжих тухай дээр 27 оны төлөвлөгөөнд яг ямар тодорхой үйл ажиллагаанууд орж ирж байгаа юм бол? Төлөвлөгөөг хараад үзэхээр хүний хөгжлийн энэ бүлэг дотор энэ гэр бүлийг дэмжихтэй холбоотой ийм ажил харагдахгүй байгаад байх юм бас зааг. Тэгэхээр энэ бодлого энэ бас энэ Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл өргөн барих гэж байгаа гэсэн. Тэгэхээр энэтэй холбоотой тодорхой ажлууд тусгагдах байсан болов уу үгүй болов уу гэж нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт нь ер нь бол гэр бүл салалт дотор чинь гэр бүл болоод 10-аад жил болж байгаа хүмүүс хамгийн их салаад байдаг юм байна л даа 60 гаруй хувь нь бол. Салалтын 60 гаруй хувийг нь эзэлдэг юм байна. Тэгээд ер нь ажил, орлого, санхүүгийн байдлаасаа болоод л ерөнхийдөө салчхаад байдаг гээд.

Тэгэхээр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай дээр бас энэ яамныхан тодорхой яг ямар бодлогыг энэ төлөвлөгөөнд оруулж ирж байгаа юм бол оо? Ахиад жаахан цаашлах юм бол Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан гэдгийн тухай дээр энийг залуу Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөв, мөнгийг нэмэгдүүлэх тухай дээр, залуучуудад хүртээмжтэй болгох тухай дээр бас бодлогын ямар дорвитойхон арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх гэж байгаа юм бол оо?

Тэгээд ер нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тухай дээр бас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болоод хөдөлмөр эрхлүүлэх эрхлэлтийг дэмжих тухай дээр бас яг ямар тодорхой үйл ажиллагаанууд оруулж ирж байгаа юм бол гэж би асуух гэсэн юм. Яагаад гэвэл энэ төлөвлөгөө дээр яг энэ тухай асуудлууд бол бас нэлээн жаахан бүрхэг, бүдэг байгаад байгаа.

Ер нь Монгол Улсын төсөвт жилээс жилд нэмэгдээд байгаа яг бодитойгоор залуу гэр бүлд та нарын төсвийн зарлага дотроос чинь яг залуу гэр бүлийг дэмжихэд ямар ямар зардлууд чиглэж очоод байгаа юм бол? Энэ нь өмнөх онуудаасаа дээшилж байгаа юм болов уу, нэмэгдэж байгаа юм болов уу, үгүй юм болов уу? Энэ тухай дээр тодорхой хариулт.

**Л.Энхнасан:** Яамнаас хариулах уу? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Гэр бүлийг дэмжих хууль талаар асууж байна л даа. Илүү нөгөө 27 оны төлөвлөгөөтэй холбоотой илүү асуулаа. Тэгэхдээ бас яамнаас хариулаад өг. Тийм төлөвлөгөө яриагүй байгаа л даа тийм өнөөдөр. Индэрт Отгонбилэг .

**Ю.Отгонбилэг:** Тэгэхээр тийм төсвийн хүрээний мэдэгдлийн хувьд бол нийт халамжийн сангаас юм уу ингээд бусад сангаас зарцуулах зардлыг яаж байгаа. Улсын хөгжлийн төлөвлөгөөний асуудал дээр бол бас яг хариуцсан хүмүүс хариулах байх. Ер нь бол Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийг төсөл өргөн барилаа гэхэд 27 ондоо бол хэрэгжих боломжгүй. Хэрвээ хууль хэлэлцээд батлагдах юм бол тухайн хуулийг бас хэлэлцэх хугацааг зааж өгөөд тухайн хугацаанаасаа хойш бол бас өөрчлөлтийн асуудлууд хийгдээд явах юм.

**Л.Энхнасан:** Энхбаяр гишүүн, сайд.

**Ж.Энхбаяр:** Яг энэ жилийн эцсийн байдлаар Монгол Улсад 3591120 хүн ам байна. Хүн ам байна. Өсөлт 2 хувь байхад хэвийн гэдэг 1 хувь бол асуудал үүсэж байна гэж үзнэ. Одоо 1011078 өрх байна. Энд сонин юм гараад байгаа юм. Нийт өнгөрсөн онд 4493 гэр бүл цуцлалт бүртгэгдсэн байгаа юм. Гэхдээ энэ нь дандаа 63.3 хувь нь 10 ба түүнээс дээш жил амьдарсан хосуудын хооронд гараад байгаа байхгүй юу. Залуучуудаасаа биш урт амьдарсан.

Нөгөө талдаа бас ийм сонин гадаад, өндөр хөгжилтэй орнуудад өрхийн орлого нэмэгдэх хэмжээнд гэр бүл цуцлалт өндөр, хүүхэд төрөлт бага нэг ийм тал байна. Тэгэхээр бид энийгээ бас их сайн судлах ёстой. Орлого, амьдралын

чанарын өөрчлөлттэй холбоотой гэр бүл, хүүхдийн тоо багасаад салалт нэмэгдээд байна.

**Л.Энхнасан:** Нэмж хариулна уу Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Тэгэхээр тэр учир шалтгааны л нийгмийн олон асуудал байна. Энийг янзлах хэрэгтэй. Олон талаас нь гаргах ёстой. гээд. Тэгээд гол нөлөөлж байгаа асуудлууд байгаа. Эх нялхсын эрүүл мэндийн асуудал, төрөлт, нялхсын эрүүл мэндийн үйлчилгээ эд нар гээд тэр чиглэлийн ажлууд нэлээн зардал нэлээн эзэлж байгаа. Дээрээс нь гэр бүлийн хүчирхийллийн салалтад нөлөөлж байгааг нэлээн хүүхэд, эмэгтэйчүүд хохирч байгаа гэдэг асуудал байгаа. Энэ дээр Хүчирхийллийн хууль гээд олон зүйл.

Тэгээд зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ЖДҮ, бичил зээл, Хөдөлмөр, нийгэм хамгааллын нөгөө сан ангийн мөнгөнүүдийг дандаа энэ чиглэл рүү нэлээн зарцуулж байгаа. Тэгээд Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн шинэчлэн батлаад тус хуулийн гарсан энэ 34 журам, стандарт шинээр мөрдөж эхэлж байгаа нь гэсэн ийм мэдээлэл байна.

Ер нь өмнөх оноос 118 хэргээр буюу 766 хувиар тус тус гэр бүлийн хүчирхийллийн хэрэг нэмэгдсэн гэдэг ийм тоо гарч байна. 1677 хэрэг 2025 оны жилийн эцсийн байдлаар бүртгэгдсэн байна.

**Л.Энхнасан:** Мөнхтуяа гишүүн асуултаа асууна уу.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор бас асуулт, саналууд байна. Ер нь бол энэ 27 оны төсөв яригдаж байгаа энэ үед ахмадуудын тэтгэврийн асуудлыг хөндөж ярьж байгаа хүн их цөөхөн харагдаад байна. Гадаа үүдээр нөгөө ахмадууд чинь жил гаран жагсчихсан байгаа шүү дээ тээ цалингаа, тэтгэврээ нэмүүлье гээд. Тэгээд энэ тэтгэврийнх нь асуудлыг яаж оруулсан юм бэ 27 оны төсөвтөө? Өнөөдөр хонины гулууз мах авахад 600 гаруй мянган төгрөг болж байна гээд ахмадууд ярьж байна.

Тэгээд өнөөдөр тэтгэврийнх нь хэмжээ нь 600-700 мянган төгрөг байгаа л даа. Тэгэхээр энэ дээр ямар ажил хийх вэ? Хэдүүлээ ер нь бол сандал суудал, албан тушаалын томилгоо болохоор үүр цүүр цайтал хуралддаг мөртөө энэ ард түмнийхээ амь амьжиргааны асуудал дээр жоохон ажил хиймээр байна. Маш олон жил энэ ахмадын тэтгэврийг индексжүүлнэ. Зөрүүг арилгана гэж ярьсан. Одоо энэ ярьсан юмаа хиймээр байна.

Ялангуяа энэ Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо энэ ахмадын тэтгэврийн асуудал, энэ тэтгэврийн зөрүү арилгах, индексжүүлэх асуудал дээр санаачилгатай, идэвхтэй ажилламаар байна гэж би хэлмээр байна. Тэгээд энэ ахмадуудаа яах вэ гадаа жагсаагаад байх юм уу? Энэ махны чинь үнэ бүүр дийлдэхээ байлаа тэнгэрт хадлаа. Тэгээд энэ төсвийн тодотголоороо ахмадын тэтгэврээ шийдэх хэрэгтэй байна даа Энхбаяр сайд аа. Ийм л юм хэлье.

**Л.Энхнасан:** Байнгын хороонууд нөгөө давхар цуг хуралдаад байгаа учраас бас зарим гишүүд бол сая орж ирлээ. Галбадрах гишүүнийг бас асуулт асуухаар нэмнэ үү. Ингээд Энхбаяр сайд хариулна уу.

**Ж.Энхбаяр:** 27 онд 2.6 их наяд төгрөгөөр манай суурь зардал нэмэгдэнэ. Энэ зардлаар зөвхөн цалин, тэтгэвэр нэмэгдэж байгаа. Энэ цалин, тэтгэвэр бүгд нөгөө хуульд заасан инфляцтай уялдуулаад нэмэгдэнэ. Бид бол Эдийн засаг, хөгжлийн яам бол 10 хувийн нэмэгдэл гэж төсвийн орон зайг нь Сангийн яаманд гаргаж өгч байгаа юм. Инфляцыг 10, дээд хэмжээ 10 дотор нэмнэ гэсэн.

Тэгэхээр намар Сангийн яам төсвөө зохиогоод ороод ирэхээр энэ тодорхой болох байх гэж.

**Л.Энхнасан:** Нэмж хариулна уу Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Тэтгэвэр бол 10 хувь инфляцтайгаа уялдуулаад 10 хувиар нэмэгдэхээр бид нар төсвийн хүрээнд орон зай, эх үүсвэр нь суулгасан гэж байна.

**Л.Энхнасан:** Мөнхтуяа гишүүн тодруулга хийе.

**Ц.Мөнхтуяа:** Ахмадын тэтгэвэр 10 хувь нэмэгдэхэд 60 мянга л нэмэгдэх байх. Тэгэхээр 1 кг махны л үнэ л юм байна л даа. Тэгээд энэ ахмадын тэтгэврийг индексжүүлнэ зөрүүг арилгана гээд их олон жил ярьж байгаа. Энэ ажлыг хэзээ эхлүүлж хийх вэ? Сандал, суудлын хэрүүл болохоор үүр цүүр цайтал хийдэг гээд би яриад байна шүү дээ. Тэгэхээр энэ асуудал руу хэзээ орох вэ гэж бас асууж байна.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариул даа.

**Ж.Энхбаяр:** Сангийн яам хариулах юм энэ дээр.

**Л.Энхнасан:** Сангийн яам Санжаадорж дарга 3 дугаар микрофон.

**М.Санжаадорж:** Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр манай төсвийн бүтэц маань өөрөө ингээд урсгал зардал, хөрөнгийн зардлын харьцаа маань бол 80 хувь орчим. Тэгэхдээ 80 хувийн урсгал зардал дотроо дахиад 80 орчим нь бол тэтгэвэр, тэтгэмж, халамж тэгээд бусад зардал болчихоод байгаа.

Бусад зардал нь бол гадаад орнуудад бид нар амласан хүүгийн зардал байдаг юу ч юм уу, цахилгаан дулааны зардал гээд ийм болчихоод байгаа юм. Тэгэхээр бид нар төсөв дотроо дорвитойхон шиг ингээд хөдөлгөөн гаргая гэхлээр угаасаа бид нар хөдлөх боломж их бага болчихоод байгаа юм. Одоо нөгөө тавилга, эд хогшил, томилолт ч гэдэг юм уу тэн дээрээс бол угаасаа орон зай гарч ирэхгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр том зардал маань юу байна гэхлээр цалингийн зардал, тэтгэврийн зардал. Тэгэхлээр бид нар энэ дээрээ нэг бол реформын хийнэ. Нэг бол бид нар эдийн засгаа томруулах л хамгийн чухал арга болчихоод байгаа юм. Хамгийн бодитой, хамгийн биелэх боломжтой зүйл нь эдийн засгаа яаж томруулах вэ гэдэг дээр л фокуслаж ажиллах.

Хэрвээ бид нар эдийн засгаа томруулж чадах юм бол одоогийн ДНБ-ийхээ 30 орчим хувиар бид нар орлогоо аваад дахин зарцуулчихна. Үүнийгээ нэмэгдүүлж чадах юм бол энэ тэтгэврийн асуудал, зовлонгууд шийдэгд.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Баярлалаа. Наранбаяр гишүүн асуултаа асууна уу.

**П.Наранбаяр:** Баярлалаа тэгэхээрээ 2, 3 асуулт байна.

Нэгдүгээрт, энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бол байнга л өгөөд байгаа зөвлөгөө байгаа шүү дээ. Наад төсвийнхөө. ДНБ-д эзлэх хувь хэмжээг 25 хувьд хүргэчих гээд. Энэ тоо руу ерөөсөө л нөгөө хязгааргүй ойртох гэдэг шиг л ерөөсөө тэгээд л ойртоод л тэгээд л ерөөсөө хүрэхгүй яваад байгаа. Тэгэхээр энэ дээр Төсвийн тогтвортой байдал энэ энэ тал дээр бас энэ миний энэ асуултад хариулж өгнө үү. Энэ яагаад энэ Засгийн газраас оруулж ирж байгаа энэ ер нь төсөөллүүд яагаад энэ хүрэхгүй байгаад байдаг юм? Яагаад гэвэл энэ 25 хувь руу ороод ирэхээрээ төсөв өөрөө инфляцыг өдөөгч биш болдог л юм байна л даа. Тэгэхээр энэ дээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дорвитой хариу нааш нь өгвөл сайн байна.

Хоёрдугаарт, энэ эдийн засгийн өсөлтийг Засгийн газар болохоороо 6 хувиар төсөөлжээ. Тэгтэл хамгийн доогуур төсөөлсөн нь бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 5 хувь, тэгээд Дэлхийн банк болохоороо 5.5 хувь, Олон улсын валютын сан 5.2 хувь гэж. Тэгэхээр энэ хэрвээ энэ өсөлтдөө, энэ төсөөлсөн өсөлтдөө хүрэхгүй бол яах юм? Засгийн газар 6 хувьдаа хүрэхгүй, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 5 хувь руу орчихвол энэ чинь нөгөө цалин хөлсний юу чинь ингээд бүгд л дутаад эхэлнэ шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар нэгэн тийм “В” plan гэдэг юм уу тийм эрсдэлийн төлөвлөгөө байна уу гэж асуух гэсэн юм. Хоёрдугаар асуулт энэ саяын асуултыг бол Засгийн газраас асууж байна.

Хоёрдугаар асуулт бол энэ хөрөнгө оруулалтуудыг яах вэ? Нэг ч шинэ юм байхгүй гэж байна. Тэгэхээр энэ боловсролыг дэмжих жил гээд 2026 оныг зарлаад энэ Азийн хөгжлийн банкаар бид нар 130-150 сая долларын хэмжээтэй зээл аваад ингээд байшин, сургууль, цэцэрлэгийн барилга бариулахаар ингээд явж байгаа. Энэ маань саяын зээлийн хууль буцсантай холбоотойгоор энэ маань хэрэгжих боломжтой болж байна уу боломжгүй болж байна уу? Энэ дээр шулуухан хариулаад өгөөч гэж хүсэх гэсэн юм.

Гуравдугаарт, энэ тэтгэврийн асуудлыг энэ БЗД-ийнхээ сонгогчидтой уулзаад явахад ахмадууд бол бүгд л ярьж байна. Энэ тэтгэвэр чинь 10 хувь нэмнэ гэдгийг бол ойлголоо. Хувийн тэтгэврийн сан эд нарыг хэзээ оруулж ирэх гээд байна вэ? Бас тэтгэврийн энэ тэтгэврийг тогтоолгох энэ сонголтуудыг бий болгож энэ чинь урагшаагаа эндээсээ бас энэ хөрөнгө, хуримтлалыг бий болгож байж эндээсээ жишээлбэл бонд босгож эд нар янз янзын хөрөнгийн янз янзын менежмент, ассет менежмент /asset management/ явж байдаг. Тэгэхээр энэ дээр бас Засгийн газар ямар бодолтой, хэр энийг хурдан явуулах вэ? Энийг асуух гэсэн юм.

Дөрөвдүгээр асуудал байна. Энэ нэмүү өртгийн албан татвартай холбоотой энэ ер нь Нэмүү өртгийн албан татварын хуулийг дагалдуулж оруулж ирэх гээд байх шиг гээд байна. Энэ дээр 13.10 гэсэн хуулийн заалт байна. Миний юуг сунгаад өгчих.

**Л.Энхнасан:** 1 минут сунгая.

**П.Наранбаяр:** Энэ 13.10 гэдэг нь ямар учиртай вэ гэхээрээ Монгол Улсын хөрсөнд ургачихсан гурил, жимс жимсгэнэ тэр хүнсний ногоонууд, дээр нь нэмээд үйлдвэрийн аргаар бэлдсэн Монгол малын мах эдгээрийг борлуулж байгаа тохиолдолд 10 хувийн татварыг авахгүй. Нойллоно гэхихсэн ийм сайн заалт бий. Гэтэл байна шүү дээ. Энэ заалт дээрээ 13.11 рүү ороод ирэхээр бол юу гээд заачхаж байна гэхээрээ дамжуулан борлуулагч бол энэ заалт хамаарахгүй. Өөрөөр хэлбэл 10 хувийг нь авна. Ингэснээрээ юу болж байна гэхээрээ аж ахуйн нэгжүүдтэй тэр үйлдвэрлэгчтэй түрээсийн гэрээ байгуулж байгаа ийм байгууллагууд бол нойллож байна. E-mart ч гэдэг юм уу, carrefour ч гэдэг юм уу тэр Номин ч гэдэг юм уу энэ томоохон сүлжээтэй ийм дэлгүүрүүд бол Монголд үйлдвэрлэсэн ийм хүнсний бүтээгдэхүүн дээр бол нойллож байдаг.

Гэтэл жижиглэн борлуулж байгаа энэ газрууд бол авсаар байгаа 10 хувийнхаа НӨАТ-ын татварыг. Энийгээ нийтэд нь ингээд чөлөөлчхөж болдоггүй юм уу? Тэр дамжуулан борлуулагч гэдэг чинь аль ч хуульд байдаггүй юм байна лээ шүү дээ ер нь. Эцсийн.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Дахиад 1 минут.

**П.Наранбаяр:** Сүүлийн асуулт энэ цалин, тэтгэврийн асуудал байна. Цалингийн хөлсний асуудал. Яах вэ энэ үйлдвэрчний эвлэл бас ажил хаяад ингээд тухайн үедээ Занданшатарын Засгийн газрын үед бол үндсэн цалинг бол 50 хувиар нэмсэн. 12 сардаа хуваагаад хүргэхүйц болгоод ингээд явсан. Гэтэл сая 11, 12 ч гэдэг юм уу оны бөгсөнд байсан бүх санхүүжилтийг нааш нь татаж ирээд бүх цалингийн бүтцийн шинэчлэлийг буцаагаад хаячихлаа. Цалингийн бүтцийг нь шинэчилье. Цалингийн бүтцийг шинэчилж байж бид үндсэн цалинг нь нэмэх ийм орон зайг бий болгох байсан. Энийгээ буцаагаад хийчихлээ. Одоо ингээд сонсоод байхад яг энэ Сангийн яам бол 600 тэрбум төгрөгийн шинээр ийм санхүүжилт хэрэгтэй гээд.

Гэтэл Цалингийн сан чинь ерөөсөө боловсролын салбарын 4.3 их наядын 3.3 их наяд. Энэ нь Цалингийн сан байгаа шүү дээ. Ингээд урсгал зардлынхаа бүүр 80 орчим хувийг ингээд эзэлчихсэн ийм юман дээр ямар ч орон зай байхгүй. Тэр 600 тэрбумыг яаж олж авах гэж байгаа юм? Энийг бас тодруулах гэсэн юм? Баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Энхбаяр сайд хариулна.

**Ж.Энхбаяр:** Энэ төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, хэмжээг тасралтгүй бууруулах бодлого барьж байгаа. Тэгж байж энэ орон зай хувийн хэвшилтэй дэмжих энэ бодлогыг хэрэгжүүлэх бололцоо үүснэ. 24 онд 37 байсан юм. 25 онд 35 болсон. Одоо бид нар ингээд 27 онд 31.9, 28 онд 30.4, 29 онд 28.6 хувь хүрэхээр тооцоод энэ төсвийн зардлыг тасралтгүй үе шаттай бууруулж байгаа. Энэ нь өөрөө зах зээл дэх төрийн оролцоог бууруулах л бодлого. Нэг асуудал.

Нөгөө талаа та урсгал зардал зохицуулахгүй, урсгал зардал нэмэхгүй бол болохгүй гэдэг юм ярьж байна шүү дээ. Тэгэхээр нэгэнт цалин тэтгэвэр, тэр нийгмийн асуудлаа шийдээд өгсөн. Одоо салбарууд, эрүүл мэнд, боловсрол,

дотоод менежментийн асуудлуудаа шийд ээ л гэж байгаа юм. Үр ашигт байдлаа дээшлүүл ээ.

Жишээлбэл, бүх сум яахаараа 12 жилийн тогтолцоо байх ёстой. 1 ангид 5 хүүхэдтэй 7 хүүхэдтэй ийм л зардал, урсгал зардал нь их өндөр тогтож байгаа сургуулийн байгууламж, байгууллагууд их олон байна л даа. Тэгэхээр үр ашгийг нь сайжруулъя. Дундын, сум дундын 12 жилийг бий болгоё. Ингээд ер нь боловсролын салбарын ингээд бага, дунд, ахлах сургуулийн юу жоохон алдагдчихсан байна гэж үзэж байгаа. Тэгээд энэ мэтчилний тэгээд дотоод нөөцөө л нэлээн шахна даа. Өөр арга байхгүй.

Эрүүл мэндийн салбарт бол эмийн зардлуудыг багасгах, эмд олгох зарим урамшуулал, хөнгөлөлтүүдийг суллах, үйлчилгээг илүү цахимжуулах гэх мэтийн дотоод арга хэмжээнүүдээ авна. Одоо Засгийн газар өөрөө хэмнэлтийн горимд өөрөө өөрийгөө шахаж дотооддоо их мөнгөгүйгээр хийх ажлуудаа хийж энийг нь хэмнэлтийг л гаргана. Тэгж байж л энд багтахгүй бол та өөрөө мэдэж байгаа өөр урсгал зардал нэмэх бололцоо байхгүй. Тэтгэврээ ямар ч байсан хуульд нийлүүлээд 10 хувь. Одоо багш, эмч нар бол маш сайн, боломжийн нэмэгдсэн.

Гадаад зээл дээр гадаад зээлийн нөгөө хууль сая унасантай холбоотойгоор Засгийн газар дахин өргөн барьчихсан Засгийн газраас. Хэрвээ тэр дэмжигдвэл бид нарт гадаад зээлийн ашиглалт нэлээн 4 их наяд гараад ирнэ. Тэр хүрээнд энэ эрүүл мэнд, боловсролын чиглэлээр баталгаажсан их сайн зээлүүд байхгүй юу. Урт хугацааны нэн хөнгөлөлттэй, буцалтгүй тусламж сайтай зээлүүд. Үүгээр манай боловсрол, эрүүл мэндийн салбарын их том асуудлууд шийдэгдэнэ шүү дээ. 17 аймгийн төв тэр чигтээ эмнэлэг нь 2 дугаар шатлал, түргэн тусламж, үйлчилгээний чадвар сайжрах. Ингээд сургууль, цэцэрлэгийн цогцолборууд тийм биз их олон асуудлууд шийдэгдэж байгаа юм. Тэрний цаана ийм зүйл байна. Тэгээд энийг бас манай гишүүд одоо энэ хууль орж ирэхээр их дэмжиж өгвөл ийм мэтчилний салбаруудын хөгжлийн асуудлууд бас хоцрогдчихоод байдаг. Тийм бололцоо бас үүсэх юм гэдэг дээр.

Тэр НӨАТ 1.8 их наядын юу үүсэж байгаа юм зардал. Хэрвээ НӨАТ-ыг 50 хувь, буцаан олголтыг 20 байгааг 50 болгочоод л төсвийн орлого 1.8 их наядаар дутаж байна гэсэн үг. Тэгээд тэгэх юм бол бид нарт 2.2 их наядын хөрөнгө оруулалт байгаа. 2.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт чинь 400 болно л гэсэн үг. 400 тэрбум үлдээд л бусад нь буцаан олголт болоод л гарчихна.

Тэгэхээр бид энэ эхэлчихсэн төсөл, хөтөлбөрүүдээ урагшлуулах нь зайлшгүй хэрэгтэй байгаад байна. Зогсоож болохгүй. Энэ чинь 3.6 их наядын хөрөнгө, төсөв, хөрөнгө оруулалтын нөгөө гүйцэтгэл яваад байдаг. Энд чинь 2.2 нь бас дутуу очиж байгаа дээр ахиад 1.8-ыг нь НӨАТ-аар буцаагаад мөнгийг нь татаад авчих юм бол тэр ажил байхгүй. Тэрний цаана чинь олон зуун аж ахуйн нэгж, хөрөнгө оруулалт, энэ бүтээн байгуулалтын олон ажил зогсчих ийм эрсдэл байгаа тул энэ НӨАТ-ын буцаан олголтын хуулийг хойшлуулъя. Хүчингүй болгоё оо. Одоо энэ намар мөрдөж эхлэх нь арай цаг үе нь болоогүй байна л гэж хэлэх гээд байгаа юм. Тэр 13.10-аа Сангийн яам.

**Л.Энхнасан:** 3 дугаар микрофон.

**М.Санжаадорж:** Санжаадорж. Мах, сүү гээд өргөн хэрэглээний бараан дээр бол нөгөө НӨАТ-гүй явж болсон нь бол миний санахын л бараг 90-ээд оноос тэгээд явчихсан байгаад байдаг. Гол зорилго нь бол тухайн үед яаж байсан гэхлээр мах, сүү гэх мэт бараануудыг болохлоор иргэд дээр шууд хүрэхдээ аль болох ченжээр дамжихгүйгээр шууд очих ёстой л гэхчээ байгаа юм.

Таны яг хэлж байгаа жишээ зөв. E-mart юм уу, Номин дээр бол бараагаа тавьчхаад зарагдсан тохиолдолд мөнгийг нь тийшээ бол өгч байгаа учраас тэр бол НӨАТ-гүй болчихоод байгаа юм. 8 нэрийн барааны дэлгүүр дээр очихлоор 8 нэрийн барааны дэлгүүр бол худалдаж авчхаад дамжуулан зарж байгаа учраас НӨАТ өгчхөөд байгаа юм.

Тэгэхээр яах вэ энийг бол яах ёстой вэ гэхлээр нэг бол бүх талд нь хасагдуулалтыг нь тооцож явах. Нэг бол энийг бүх нийтээрээ НӨАТ-аа төлдөг ийм л зарчим руугаа явах ёстой юм байгаа юм уул нь бол. Тэгсэн тохиолдолд бол энэ асуудал бол бүрэн шийдэгдэнэ.

НӨАТ бол өөрөө бол хэрэглээний л татвар шүү дээ. Тэрнээс аж аж ахуйн нэгж дээр бол ачаалал үүсэх ёсгүй ийм л татвар байгаад бол тийм.

**Л.Энхнасан:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. 5 дугаар микрофон.

**А.Энхбат:** Наранбаяр гишүүний асуултад хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат. Тэгэхээр бид нар энэ төсвийн зардалтай холбоотой асуудлыг яриад байна. Энэ маань эдийн засагт оролцох оролцооны түвшнийг ерөнхийдөө цаад утгаараа ярьж байна гэсэн үг.

Ер нь бид нар Монгол Улс ДНБ төсвийн зарлага өнгөрсөн хугацаанд буюу өнгөрсөн 2000 оноос 2023 оны тоон шинжилгээ дээр экономит шинжилгээ хийж үзэхэд ер нь эдийн засгийн өсөлтийг бодит эдийн засгийн өсөлтийг хангахад манай төсвийн зарлага дунджаар 27 хувьтай байхад их зохимжтой гэж гарсан байгаа. Тэгэхээр өргөн мэдүүлсэн энэ Төсвийн хүрээний мэдэгдэл энэ төсөл дээр бол ДНБ-д эзлэх хувь хэмжээг 31.9-28.6 хүртэл ингээд бууруулахаар явж байгаа.

Гэхдээ ерөнхийдөө энэ зарлагын өсөлт нь 2024 он хүртэл огцом өссөнтэй харьцуулахад жишээлбэл энэ өсөлт бол жишээлбэл нэлээн өндөр.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Нэмж хариулах уу? 5 дугаар микрофон.

**А.Энхбат:** Тэгэхээр та бүхэн мэдэж байгаа Улсын Их Хуралд жишээлбэл 2025 оны 6 дугаар сард төсвийн тодотголыг боловсруулсан. Улмаар төсвийн хүрээний мэдэгдлийг нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тэр үед бол 25 онд батлагдсан төсвийн зарлагыг 1.9 их наядаар бууруулж байсан.

Харин 26 оны төсвийн зарлагын өсөлтийг 4.5 хувьд хадгалсан хэт тэлсэн өмнөх алдааг бол засаж байсан. Ер нь цаашдаа төсвийн зарлагын өсөлтийг цаашид хэт тэлэхгүй байх нь макро эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн тогтвортой байдал бол цаашаа эдийн засгийн тогтвортой өсөлтөд бол чухал нөлөөтэй байгаад байгаа.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд нэмж хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Энэ боловсролын салбарын хувьсах зардлын бараг 90 хувь болчихсон байна. Багшийн цалин эзэлж байгаа юм байна. Их өндөр гараад ирлээ. Боловсролын салбарын цалингийн сан 3.2 их наядаас 4.2 их наяд болж нэмэгдэж байгаа. 27 онд боловсролын салбар Монгол Улсын нийт төсвийн төсөвт 6.2 их наяд төгрөг хүрэхээр ингэж тооцоологдож байна. Боловсролын салбарын төсөв нэмэгдсэнээр дотоодын бүтээгдэхүүний 7 хувь бараг хүрч байна. Улсын төсвийн нийт зардлын 22 хувь боловсролын салбарт очиж байна. Тэгэхээр их өндөр.

Нөгөө талдаа гишүүд, бид эдийн засгаа томруулахгүй бол нийт төсвийнхөө 22 хувийг боловсролд зарцуулсан хэдий ч нөгөө эдийн засаг маань бага болохоор очиж байгаа юм маань олон улсын хэмжээнд үзэхэд бид нар 1 хүүхдэд ноогдох зардал 1500 орчим ам.доллар. Бага л байгаа байхгүй юу. Энэ бол өндөр хөгжилтэй орнуудад бол 10 мянга орчим хүрч байгаа тийм биз. Их дээр явж байгаа. Тэгэхээр бид эдийн .../минут дуусав./

**Л.Энхнасан:** Галбадрах гишүүн асуултаа асууна уу.

**Ж.Галбадрах:** Сайн байцгаана уу? 29 он хүртэлх 3 жилийн төлөвлөгөөгөө бид гаргаж байна. Улсын хөгжлийн 27 оны төлөвлөгөө энэ хүрээнд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд боловсролын салбарыг дурдаагүй байна. Өмнө нь бол үргэлж боловсролд тэргүүлэх салбар байна гэж ярьсан. Би уншаад бас олсонгүй. Тэгээд яагаад, ямар үндэслэлээр энийг ингээд тусгаагүй вэ гэдгийг асууя.

Тэгээд хүний хөгжил бол ерөөсөө улсын хэмжээнд байнга л тэргүүлэх салбар, чиглэл байх ёстой. Байсаар ч байх ёстой. Сая Энхбаяр сайд бол хэлээд байна л даа эрүүл мэнд, боловсролд бид нар ер нь хамгийн их анхаарсан, хамгийн их хөрөнгө оруулалт оруулсан гээд байна. Үнэндээ бол энэ бол зөрүүтэй, андууралтай байна. Боловсролын салбарт сүүлийн 2 жилд оруулсан хөрөнгө оруулалттай энэ 27 оны хөрөнгө оруулалтыг та бүхнийг бас харьцуулаад тоо хэлээч ээ гэж хүсэж байна. Одоо энд бол гадаадын хөрөнгө оруулалт, мөн дотоодын хөрөнгө оруулалт гэдэг тоонууд бол нэлээн өндөр тавигдсан байгаа. Яг улсын төсвөөр оруулж байгаа хөрөнгө оруулалт өмнөх 2 жилтэйгээ харьцуулахад өссөн үү, буурсан уу гэдгийг би асуумаар байна.

Тэгэхээр бид бол ингээд хүнээ хөгжүүлээд боловсролдоо их хөрөнгө оруулаад байгаа энэ бол байдаг юм, ер нь л оруулчхаад байгаа шүү гээд ингээд яриад байна. Тэгээд энэ бол маш хангалтгүй байгаа. 27 оны жилийн ажлын төлөвлөгөөг бид нар бас харсан. Тэнд байж байгаа хөрөнгө оруулалтуудыг оруулж ирж байгаа юмнууд бол энэ эрэмбээ сайн тогтоогоогүй ийм оновчгүй байдал бол байсан гэдгийг та бүхэндээ бас хэлье.

Дараагийн нэг зүйл бол энэ төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөлд бол ДНБ-ий өсөлтийг 5.8-6.3 гэж тогтвортой өссөөр байхаар тусгасан байгаа. Тэгвэл 1 хүнд оногдох ДНБ-ийг бодитоор өсгөхийн тулд нэгдүгээрт эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх ёстой. Бид нар яаж төрөлжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх ёстой, өсөлтийг иргэдэд тэгш хүртээх ёстой. Тэгээд энэ чиглэлээр ямар арга хэмжээнүүд яг тодорхой тусгагдсан бэ? Эдийн засгийн бүтцийг бид

төгөлдөржүүлэхийн тулд зөвхөн уул уурхайн экспортод түшиглээд явах бол эрсдэлтэй байгаа гэдгийг бид бүхэн ярьж байгаа.

Түүнчлэн импортын бүтээгдэхүүний үнэ савлагаатай байгаа. Ийм үед бид нар яаж төрөлжүүлэх вэ? Мөн импортыг орлох гол нэрийн бүтээгдэхүүнийг дотооддоо дэмжиж хөгжүүлэх талаар ямар бодлого төсөөлөл байгаа вэ? Засгийн газрын чөлөөлтийн санаачилгаар олон үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхэлж болохоор бид нар бас болж байх шиг байна. Ингэснээр магадгүй олон айл өрх, иргэн өөрөө өөртөө ажил олгогч болж өрхийн орлогоо нэмэгдүүлж, эдийн засагт бодит нэмэр болох боломж бүрдэнэ. Гэвч эдгээр зөвшөөрөл шаардахгүй үйл ажиллагааг стандартын шаардлага хангаж байгаад эсэх.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Галбадрах гишүүн ээ энэ нөгөө хөгжлийн хөтөлбөр дээр орох асуултууд асуугаад байна. Одоо чинь дандаа төсвийн хүрээ талдаа яваад байна. Би тэр талын юмнуудаа аваад ирчихсэн. Төсвийн хүрээнээ дандаа макро тоон дээр ярина. Ер нь ингээд эдийн засгийн хувьд эдийн засгийн хувьд өсөлтийг 5.8 хувь байлгана гэдэг маань өсөлт яаж хангагдах юм бэ гэж. Хэдийгээр нөхцөл байдал амаргүй ч бас сайн мэдээнүүд бас байгаа. Бид нөгөө олон жил яригдсан хил холболт, боомтын ажлууд, боомтыг ухаалаг гарц нэмэгдүүлэх ажлууд сайн явагдаж байгаа. Нүүрс олборлолт, нүүрсний экспорт эрс нэмэгдсэн. Ноднингийн мөн үеэс 60 хувь нэмэгдчихээд байж байна.

Төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэж байна, зэс төмрийн үнийн төлөв байдал эвтэйхэн байна. эрэлт сайн байна. Ган, зэс, нүүрс боловсруулах томоохон төслүүд гараасаа хөдөлж байна. Эрчим хүчний асуудал. Одоо бид 1 номерын тулгамдсан асуудал бол эрчим хүч. Одоо Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл дээд хүчин чадалдаа хүрсэн. Одоо шинээр ашиглалтад орох аливаа нэгэн байшин барилга, төсөл хөтөлбөрийг цахилгаан, дулаанаар хангахад туйлын хязгаарлагдмал болж байгаа юм. Энэ чинь муу гэсэн үзүүлэлт биш. Байгаа хүчин чадлаа бүрэн ашиглачихлаа, импортынхоо шугамыг ачааллыг бүрэн авчихлаа. Одоо бидэнд дараагийн шинэ шинэ цахилгаан станцууд, эх үүсвэрүүд хэрэгтэй болж байна. Энэ хүрээнд энэ ... Чойрын хооронд Баян болон Бөөрөлжүүт, ТЭЦ V, Тавантолгойн цахилгаан станц, нүүрсний цахилгаан станц гээд, Сэлэнгэ эд нар гээд олон төслүүд ид ажил, барилга угсралтын ажлууд нь явж байна. Зарим нь эхэлж байна. Энэ ажлууд их сайхан өөдрөг байгаа.

Тэгээд олон жил маргалдсан ураны төсөл ашиглалтад үйл ажиллагаа эхэлсэн. Баяжуулалт эхэлж байна. Эрдэнэбүрэний УЦС-ын барилга угсралт ид үргэлжилж байна. Алтанширээгийн нефть боловсруулах үйлдвэрийн ажил ид үргэлжилж байна. Үйлдвэр, технологийн паркууд буюу хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын ажлууд явж байна. Гадаадын томоохон хөрөнгө оруулалт, саналууд бас нэлээдгүй бас орж ирж байна. Тэгэхээр ер нь манай эдийн засаг дунд хугацаандаа ер нь энэ өсөлтийн 5-7 хувийнхаа төлөвлөгөөг хадгалаад л явчихна, явах нь.

Энийгээ дагаад л хүний нөөц, ажиллах хүч, тэгээд л эрх зүйн орчин, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хувийн хэвшлийг дэмжих, энэ өмчийн халдашгүй дархан байдал, энэ бизнес эрх чөлөө, зөвшөөрөл, хүнд суртлыг арилгах, авлигатай тэмцэх гэх мэтийн эдийн засгийн чиглэлийн хуулиуд энэ 5, 6

сард ч энэ хаврын чуулганд бол Засгийн газраас бүрэн багцаараа орж ирнэ. Тэр үед засгийн бодлого бол нэлээн их ойлгомжтой болох болно гэдэг.

Эдийн засгийн өсөлтийн тоо бол саяын дурдсантай ганц манайх биш Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк бүгд манай тооцоололтой 1, 2, 1, 2 функтийн зөрүүтэйгээр ойролцоо тусаж байгаа. Ер нь ирээдүй төлөв бол тун эвтэйхэн. Энэ дунд хугацаанд яг энэ шатахууны хараат байдал, энэ импорт, энэ шатахууны огцом өсөлттэй холбоотой манай эдийн засагт ийм шок өгөөд явлаа.

Дээрээс нь энэ урсгал зардлын огцом нэмэгдүүлэлт, энэ эрүүл мэнд, боловсролын салбарт гарсан цалингийн өндөр өсөлт, жоохон тооцоолол дутуу хийгдэж огцом их нэмэгдэж байгаа, тэтгэврийн нэмэгдлүүд, энэ инфляцад холбоотой хуулиар дагасан нэмэгдлүүд маань төсөвт бол их их өндөр ачаалал үүсгээд байна. Тэрнээс төсөв бол олдог мөнгөө олоод ноднингийн мөн үетэйгээ адилхан татвар хураамжид цуглаад ингээд явж байна.

Манай уул уурхайн салбарын ажил нэлээн идэвхтэй, экспортын үр дүнгүүд нэлээн харьцангуй өндөр. Ноднингийн мөн үеэсээ бараг 2.2 тэрбум долларын илүү экспорт хийж, энэ орлого бүрдүүлэхэд нэлээн том хувь нэмэр оруулж байна. Ялангуяа үндэсний Эрдэс Тавантолгой компанийн ажил бол маш сайн байгаа. Зөвхөн он гараад 1 тэрбум долларыг Монгол Улсад валютын нөөц болгож бүртгүүлж.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Боловсролын чиглэлийн хөрөнгө оруулалтыг Энхбаяр сайд хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Шинэ хөрөнгө оруулалт байхгүй. Тэгэхээр гадаад зээл, гадаад зээлийн ашиглалт, боловсролын салбарын асуудлууд нэлээн энэ дээр боловсролын салбар чинь 682 сая долларын гадаад зээлийн ашиглалт явж байгаа. Энийгээ л ашиглалтаа сайжруулна. Нөгөө Алтанширээ, Эрдэнэбүрэнг тусад нь гаргачихвал энэ төслүүд маань орон нутгийн, дэд бүтцийн, эрүүл мэндийн, боловсролын, хот байгуулалтын гээд энэ олон төсөл орж ирэх гээд байдаг. Тэгээд бид чинь нөгөө сая тэр дээр жоохон асуудал гарчихсан. Энийгээ залруулчихвал энэ болгон чинь л хэрэгжих орон зай нь үүсчих гээд байгаа юм л даа.

Салбарын шинэчлэлүүд нэлээн явна. Энэ нөгөө түрүүний ярьсан энэ Улаанбаатар хотын 3 мянгаас дээш хүүхэдтэй 38 сургуулийг задалж, хотхоны бага сургууль, дунд сургууль, төрөлжсөн ахлах сургууль болгоно гэсэн ийм зорилтыг Боловсролын яам ярьж байгаа. 2026 оны 9 сарын 1-нээс өмнө 20 сургуулийг 1 ангид 35 хүүхэдтэй байх стандарт.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Галбадрах гишүүн нэмж асууя гэсэн. Тэгээд сайд нэмээд хариулчхаарай.

**Ж.Галбадрах:** Боловсролын салбарын дотоод нарийн юмыг бол сайдаас нь асууя. 27 онд орлогыг 33.6 их наядад хүргэнэ гэсэн байгаа. Тэгээд бид Улсын Их Хурал дээр олон хяналтын сонсгол, хянан шалгах түр хороо байгуулж ажилласан. Үүний үр дүнд бол хууль хяналтын байгууллагаар шалгагдаж шийдэгдсэн хэргүүд, тэдгээрийн үр дүнд хөрөнгө хураах, ял, хариуцлагаас улсын төсөвт хөрөнгө

төвлөрүүлэх гэсэн энэ зүйлүүд яригдаж байсан. Тэгэхээр энэ тооцоо энд орлого бүрдүүлэхэд тусгагдсан уу гэдгийг нэмээд асууя.

**Л.Энхнасан:** Боловсролын яамнаас Адьяасүрэн дарга хариулах уу? Индэр дээр хариулна уу.

**Э.Адьяасүрэн:** Боловсролын яам Адьяасүрэн. Гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн 2 жилийн хөрөнгө оруулалтын салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар асуусан. Энэ дээр 2024 онд бол 723 тэрбум төгрөг төлөвлөсөн. 25 оны хувьд бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 446 тэрбум төгрөгийг төлөвлөсөн. 26 онд 506.7 тэрбум төгрөг төлөвлөсөн байгаа. 27 оны хувьд бол улсын хөгжлийн төлөвлөгөөнд бид нар саналаа хүргүүлсэн. Тэгээд одоо төслийн түвшинд явж байгаа учраас шууд тодорхой тоо хэлэх бол боломж байхгүй байна.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд нэмж хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Энэ эдийн засгаа 2027 онд 5.8 хувиар өсгөнө. Инфляцыг 7 хувь дээр барина. Нийт орлогоо 34.7 их наяд дээр оруулна гээд энэ болгон чинь л зорилт байхгүй юу. Тэгэхээр дандаа өсгөж байгаа нь засаг өөртөө зорилт тавьж байна, өөрийгөө шахаж байна гэсэн үг. Дотоод нөөцөө дайчилж байна л гэсэн үг. Буугаад ороод ирэх юм бол та нар загнах ёстой байхгүй юу. Яагаад эдийн засгаа ийм бага тооцож байна, инфляцаа яагаад ингэж их өндөр үзэж байна, яагаад орлогоо ингэж багасгаж тооцож байна. Энэ дандаа өсгөж орж ирж байгаа буюу засаг өөрийгөө дайчилна, боломж байна, дотоод нөөцөө шавхана, урагшилна, илүү орлого хийнэ, илүү экспорт хийнэ, илүү хөрөнгө оруулалтыг татна, илүү үр ашигтай байна. Энэ зарлагын хөл дээр ... 31, 30, 28 гээд тасралтгүй буулгаж байгаа шүү дээ. 37-гоос буулгасаар байгаад бид нар 27 онд 31.9-рүү аваад ирнэ. 29 он гэхэд бид нар 28-даа ороод ирнэ. Энэ их том амжилт болно. 28 руу 20 руу ороод ирнэ гэдэг чинь хувь.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Баярлалаа. Саранчулуун гишүүн асуултаа асууна.

**О.Саранчулуун:** Сайн байна уу. Төсвийн хүрээний мэдэгдлийг харахлаар манай улсын 5 төрлийн орлого, аж ахуйн нэгжийн орлого 10 хувиар, нийгмийн даатгалынх 10 хувиар, АМНАТ 2.6 хувь, НӨАТ 8.2 хувь, Хувь хүний орлогын албан татвар 12.8 хувиар өснө гэдэг ийм төсөөлөлттэй ийм материалыг бид нар харж байна. Тэгэхдээ энэ нөгөө Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, аудитын бас тэмдэглэл, дүгнэлт нь байх шиг байна л даа. Тэндээс харахлаар юу гэж дүгнээд байна гэхлээр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдээ өмнөх жилийнхээ коментуудыг хэвээр нь үлдээж байна, хэт өөдрөг төсөөлж байна, зарим асуудлыг тооцоогүй байна гэдэг коментууд нь ингээд дандаа үлдээд байна л даа. Өмнөх жил ч гэсэн иймэрхүү л юм харагддаг. Тэгэхээр энэ Тогтвортой байдлын зөвлөлөөс өгдөг зөвлөмж нь аудитын зөвлөмж энэ тэр нь тэгээд ер нь хэрэглэгддэг юм уу, эсвэл энэ жилээс жилд ингээд энийгээ давтаад л яваад байдаг юм уу гэдгийг би бас сайн ойлгохгүй байгаад байна.

Ер нь ингээд харахаар төсвийн орлого саяын миний хэлсэн 5 эх сурвалжаас их төрөл нь 28 онд 29 онд өснө гэж байгаа байхгүй юу. Яг өдөр тутмын амьдрал дээрх татварын орлого ч гэсэн өснө гэж байна. 27 онд 24, 28 онд 25.7 хувь, 29 онд 27.4 хувь өснө гэнэ. Энэ өсөлтөө тооцохдоо тэгвэл аж ахуйн нэгжийнхийг яадаг юм

бэ гээд тооцсон чинь дандаа том аж ахуйн нэгжийн илүү тооцдог юм байна л даа. Уул уурхай, томоохон аж ахуйн нэгжүүд тооцдог.

Өөрөөр хэлбэл, энэ орлого нь 50 хувь нь уул уурхайн салбар гэж байгаа юм. Тэгээд жижиг аж ахуйн нэгжийн хувьд ер нь энийг хэр жин эзэлдэг юм бол гэдгийг нарийвчилж бас хүмүүс мэдэх хэрэгтэй байх гэж бодож байна. Яагаад тэрийг үзэж байгаа гэхлээр бид нарын нүдээр харахад өдөр тутмын амьдралд ингээд үзэхэд жижиг аж ахуйн нэгжүүд бол дампуурч байгаа шүү дээ. Дээрээс нь хэрэглээний үнэ буурна гээд байх юм. Махны үнэ бараг өмнөх жилээсээ асар үнэтэй болчихоод байхад яаж бодохоороо хэрэглээний үнийг буурна гэж тооцоолоод байдаг нь би ерөөсөө биеэ ойлгохгүй байна уу эсвэл энэ дээр үнэхээр ингээд биччихсэн байгаа юм уу гэдгийг нь ойлгохгүй байгаад байна.

Дараагийнх дээр нь ингэсэн байгаа 103 дугаар хуудсан дээр байна л даа. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.7, 8, 9 дээр заасны дагуу төсөв төлөвлөгөө нэлээн орсон зүйлүүдийг л ийшийгээ тусгах нь зүйтэй гэдэг ийм дүгнэлт үзчихсэн байгаа. Одоо энэ номын дараа бид нар төлөвлөгөө харах юм бол төсөв төлөвлөгөө тусгаагүй ажлууд яам болгон дээр байгаа байхгүй юу. Тэгэхээр тэд нар ингээд байх байхгүй болно гэсэн үг үү гэдгийг бас тодруулж бас асуумаар байгаа юм.

Хамгийн сүүлд нь шинэчлэл хийх юм байна. Тэр нь татварыг үе шаттайгаар олон улсын стандартад нийцүүлж бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулна гэж байна. Би 1 минутаа нэмээд авчихъя тэгэх үү? Тэгэнгүүт яг энэ НӨАТ-ын шинэчлэлээр чинь үр шимийг хүртэх чинь яг хэн байх юм? Тэдэн аж ахуйн тэдэн хүнтэй, тэдэн хүний нөөцтэй гэдэг юм уу тэд.../минут дуусав./

**Л.Энхнасан:** 1 минутыг нь нэмье.

**О.Саранчулуун:** Яг үүний үр шимийг хүртэх чинь ийм ийм мэдээлэл хүмүүст очмоор байгаа байхгүй юу. 26 оны 10 сарын 1-нээс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байгаа энэ шаталсан хэлбэрээр нэмэгдүүлэх НӨАТ-ын урамшууллын буцаан олголтын асуудлыг ярьж байгаа юм нь үр шим нь иргэн, өрх, аж ахуйн нэгж, байгууллагад яаж тусах юм, амьдралд яаж тусах юм гэдгийг нь мэдмээр байгаа байхгүй юу.

Тэгээд дахин тодруулъя. Махны үнэ бол хамгийн өргөн хэрэглээнд хэрэглэгддэг үнийн өсөөд байхад хэрэглээний үнийн өсөлтийн түвшинд махны үнэ огт ордоггүй юм уу, эсвэл яахлаараа 27 онд 7, 28 онд 6, 29 онд 5 функтээр өснө ингэж шууд буурахаар харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр яагаад махны үнэ өсөөд байхад энэ ном дээр буурах юм байгаад байгааг би ойлгохгүй байгаад байна л даа.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариулна уу.

**Ж.Энхбаяр:** Мах бол яг улирлын чанартай. Намар бол нийлүүлэлт ихсээд сайхан үнэ буураад ирнэ, хавар жоохон өсөлт үүснэ. Тэгэхээр энэ чинь 430 төрлийн барааг ер нь хүний хамгийн өргөн хэрэглэдэг 430 барааг л жигнэсэн дундаж үнэ гарч байгаа шүү дээ. Энэ дотор хүнсний багц гэж байна. Хүнсний багц дотор чинь мах жоохон өсөлттэй, хүнсний ногоо өсөлттэй, гурилан бүтээгдэхүүн өсөлттэй гарсан. Энийг бол манай дотоодоосоо хангаад зохион байгуулаад бид

нар буулгах арга хэмжээг Засгийн газар аваачиж хэрэгжүүлж бололцоотой тул бууна гэж үзэж байгаа. Ер нь улирлын чанартай буудаг.

Дээрээс нь ТЭЗҮ, зураг төсөлгүй эх үүсвэр нь батлагдаагүй зүйлүүд батлагдахаа больж байгаа буюу яг манай гишүүд орж сая нөгөө санал гаргаад асуудал баталдаг шүү дээ. Энэ асуудлууд чинь явахаа болино л гэсэн үг. 26, 30 оны хөгжлийн хөтөлбөрөө баталсан. Хууль нэлээн чангарсан. Зөвхөн эх үүсвэртэй, техник засгийн үндэслэлтэй, хэрэгжихүүд үр ашигтай гэдэг маш олон шалгуур босго тавьчихсан. Тэгэхээр тэр хүрээндээ л явна. Тэрнээс шинэ зүйл орж ирэх бололцоо маш хязгаарлагдмал. Үнэхээр гадаад зээлийн эх үүсвэр нь шийдэгдээд, зураг төсөл нь гараад үр ашигтай гэсэн ач холбогдолтой төсөл орж ирвэл тэрийг Их Хурал ярьж байгаад 1, 2-оор нь нэмнэ гэсэн үг.

Тэрнээс одоо энэ хөгжлийн бодлого тогтвортой, улс төрөөс ангид хэрэгжихүйц урт хугацаандаа тогтвортой аль ч нам улс төрийн эрхэнд гарснаас үл хамааран хэрэгжих байдлаар бид нар чинь Үндсэн хуульдаа өөрчлөлт хийж байгаад, 5 нам зөвшилцөж байгаад энэ хуулийг баталсан шүү дээ төсвийн тогтвор биш ээ, хөгжлийн хөтөлбөрийн тогтвортой хэрэгжих асуудлаа. Тэгэхээр энэ талдаа.

Тэгэхээр үнэ дээр бол засаг бол энэ үнийн өсөлтийг 7 хувь дээр барина л гэсэн зорилт. Энэ бол засаг даалгавар авч байна гэсэн үг байхгүй юу. Тэрнээс одоо ийм байгаа юм байна өндөр тавьчихъя гэдэг юм байж болдоггүй. Энэ чинь бас зах зээлдээ буруу сигнал очдог. Нөгөө иргэдийн худалдан авах мөнгө үнэгүйдэх юм гарна. Тэгэхээрээ засаг бол 7 дээрээ барина. Тийм бүрэн бололцоо байна.

Нийт татварын маань 90 гаруй хувь нь том аж ахуйн нэгж дээр л байгаа юм. Энэ манай эдийн засгийн бүтэцтэй холбоотой. 90 гаруй хувийг л энэ хэдхэн том аж томоохон аж ахуйн нэгжүүд л бүрдүүлж байгаа. 5 гол орлогыг 10 хувиар. Тэгэхээр бид нар энэ бүх томоохон а аж ахуйн нэгжүүдтэйгээ үндсэндээ нэг бүрчлэн хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, бизнес, хөрөнгө оруулалт, экспорт, импорт гээд бүх тоонуудаа гээд авчхаж байгаа юм.

Тэгээд тэн дээр тооцоод ямар ч байсан бид нар дунджаар эдийн засгийнхаа 7 хувьд, 5-а7 хувьд Монгол Улс өсгөөд байх бүрэн суурь чадавх байна. Түрүүний нэрлэсэн нэлээн томоохон төсөл, хөтөлбөрүүд, хөрөнгө оруулалтууд бас чамлахаар чангатгах гэж бодлогын арга хэмжээнүүд урагшилж байгаа. Эрчим хүчний, дэд бүтцийн томоохон төслүүд явж байна. Барилга угсралтууд нэмэгдэж байна, экспорт нэмэгдэж байна, импорт нэмэгдэж байна. Тэр хэмжээнд л импорт нэмэгдэх хэмжээнд чинь л гааль, НӨАТ-ын орлого ороод л ирнэ шүү дээ. Экспорт гараад л байвал манай АМНАТ, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар чинь нэмэгдээд л байна гэсэн үг. Тэгэхээр боломжийн.

Харин даруу байгаа шүү. Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөр баталсан ийм туйлын үнэн байх зүйл биш. Эд нар чинь нөгөө нэг хязгаарыг нь гаргаад өгнө. Манайх өөрсдөө тооцоо гаргана. Та бүүр сонирхвол би танд сүүлийн 3 жил, 4 жилийн хэрэгжилтийг гаргаад өгөх үзэхэд бол ер нь л тэн дээр тодорхой болно. Ноднин бол бас л ийм бас л шүүмжлэл өөдрөг байна гэсэн шүүмжлэл гарсан.

Гэхдээ бүгд биелсэн буюу яг зорилтдоо хүрсэн л гэсэн үг. Тэр тооцоолол, төсөвлөлд зөв очиж байна л гэсэн үг. Их айхтар хол зөрөөд байхгүй. Бодлогын арга хэмжээгээ уялдуулна, статистиктайгаа, Монгол банктайгаа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэйгөө, тэгээд л бүх яам, байгууллагууд, тэгээд томоохон аж ахуйн нэгжүүд, яг гол экспортлогч, импортлогч нар гээд бүгдээр нь тоо баримтаа тулгана шүү дээ. Тэгээд үзэхээр ер нь их ханатай гардаг болчихсон. Энэ чинь аргачлал эд нар нь ижил төстэй олон улсын стандартад нийцчихсэн. Тэгэхээр энэ дээр тоондоо алдаад л байдаг юм гайгүй болчихсон. Харьцангуй их сайн. Нөгөө талдаа төсвийн сахилга.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Саранчулуун гишүүн тодруулга хийх үү?

**О.Саранчулуун:** Баярлалаа. Би дахиад тодруулах гээд байгаа юм. Тэгвэл нийт аж ахуйн нэгжийн орлогын нийт бүрдүүлж байгаа, том аж ахуйн нэгж 90 хувь нь байдаг гэж байна. Үлдсэн 10 хувь нь бол жижиг, дунд аж ахуйн нэгж юм байна л даа. Тэгвэл тэр жижиг, дунд аж ахуйн нэгжид ажиллаж байгаа хүмүүсийнх нь тоо, тэр орлогын ихэнхийг бүрдүүлээд байгаа, 90 хувийг бүрдүүлээд байгаа тэр том аж ахуйн нэгжийн хүмүүсийн тооны харьцаа хэд вэ? Тэрийг эргээд харчихъя тэгэх үү? Тэрний чинь цаана айл өрхийн асуудлууд байгаа. Нэгдүгээрт.

Хоёрт гэх юм бол би дахиад асууя НӨАТ-ын хуулийн шинэчлэл, НӨАТ-ын татвартай холбоотой энэ хуулийн шинэчлэлд нь ямар үр шимийг хүртэгчдийг хэдүүлээ тодорхойлъё оо ийм ийм ийм ажил хийдэг, ийм ийм, аж ахуйн нэгж ийм ийм юм дээр яг шууд үр шим нь ингэж хүртэх юм аа, шууд бусаар үр шим нь ийм байх юм гэдэг нь иргэдэд мэдээлэл өгүүлэх гээд би дахин дахин асуугаад байгаа шүү.

**Л.Энхнасан:** Энхбаяр сайд хариулах уу?

**Ж.Энхбаяр:** Бид нарын зориод байгаа нийгмийн асуудал, ядуурал, ажилгүйдэл гээд олон юмыг хэн шийдэх юм бэ гэвэл хувийн хэвшил л шийднэ. Тэгэхээр засгийн бодлого бол бизнес эрхэлж байгаа хувийн хэвшлээ, гадаад хөрөнгө оруулагчдаа дэмжих чиглэл рүү л яваад байгаа. Яг иргэд рүү чиглэсэн хуваарилах, халамж тараах талаасаа илүү энэ бизнесээ дэмжих татварын багц хуулийн өөрчлөлт дандаа тэр НӨАТ-ын өөрчлөлт, аж ахуйн нэгжийн өөрчлөлт дандаа тэгж яваа. Бага, дунд бизнес нөгөө 6-10 тэрбумын аж ахуйн нэгжүүдийн 15 хувиар татвар төлөх, дундын шатлалыг нэмж байна. Энэ чинь нийлээд 600 гаруй аж ахуйн нэгжийн ачааллыг бууруулж байгаа юм. 400 сая хүртэл хүрэх нөгөө борлуулалтын орлоготой бизнес эрхлэгчдийг бизнесээ идэвхжүүлж тэлэх бололцоог нь хангаад ингээд энэ НӨАТ-ын өөрчлөлтүүд орж ирж байна гэх мэтийн.

Тэгээд нөгөө хэрэгжүүлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөө аж ахуй дэмжиж байгаа энэ төсөл, хөтөлбөрүүд чинь дандаа энэ хамгийн их ажлын байр. Ер нь манай нийт эдийн засгийн 47 хувь байх. Худалдаа үйлчилгээ энэ жижиг бизнес байгаа шүү дээ. Тэгэхээр энэ рүүгээ чиглэсэн мөнгөний нийлүүлэлтийг.../минут дуусав./

**Л.Энхнасан:** Дахиад тодруулга тэр Сангийн яамнаас асуугаад байх шиг байна тээ илүү.

**О.Саранчулуун:** Яах вэ би тэр тоог бол авах хүсэлтэй л байна. Яагаад гэхлээр бид нар нөгөө 80:20-ийн зарчим гэж ярьдаг шүү дээ. Нийт ард түмний баялгийн 80 хувийг 20 хувь нь эзэмшдэг ч билүү бид нар ингээд л ярьж л байдаг тээ. Гэтэл бүтээж байгаа хүмүүс нь 80:20-ийм стори ярьдаг тээ? Тэр шиг зүй тогтол харагдаад эргээд энэ том аж ахуйн нэгжид ээлтэй хууль, бодлого эрх зүйн орчин нь илүү яваад жижиг, дунд буюу дунджаар 10 хүнтэй, 5 хүнтэй ажилладаг үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд хэр ээлтэй байна вэ гэдгийг бид нар харах ёстой байхгүй юу. Тэгээд тиймэрхүү аж ахуйн нэгжид зориулсан, өрхийн аж ахуйн нэгжид зориулсан ч юм уу тийм шинэчлэл, дэмжлэгийг хармаар байгаа юм л даа.

Тэгэх юм бол энэ чинь уул нь яг иргэнд ээлтэй гэдэг юм бас баймаар харагдаад л би асуугаад байгаа юм. Тэгээд үр шимийг хүртэгчдээ бүгдээрээ ил тод болгож бас ойлгуулах хэрэгтэй байх иргэдэд.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Гишүүд асуулт асууж. Хариулах уу? Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Яг Саранчулуун гишүүний хөндсөн яг энэ сегмент гол салбар болсон хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл дээр өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн Атар-ын, Цагаан алт, Хүнсний хувьсгал энэ хөтөлбөрүүд байна шүү дээ. Бараг 5 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй зээл, дэмжлэг, татаас очсон. 38 мянган ажлын байр шинээр бий болсон. Олон 10 боловсруулах үйлдвэрүүд хүнсний үйлдвэрүүд бий болсон. Мянгаар тоологдох шинэ бүтээгдэхүүн бий болсон.

Энэ салбарын эдийн засаг дахь оролцох оролцоо нөлөөлөл эрс нэмэгдсэн. Одоо энийг нь бид нар дэмжээд Евроазийн эдийн засаг буюу зах зээл рүү нь сэрүүн бүсийн зах зээлийг нээж өгч байгаа. Энэ бол маш сайн үр дүнгээ олсон хөтөлбөрүүд болсон шүү. Ийм мэтийн хөтөлбөрүүдээ л бид нар аль болох яг тэр эдийн засгийн 40 гаруй хувийг бүрдүүлж байгаа худалдаа, үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл. Энийг бол байнга авч явах ёстой салбар манай. Мэдээж гол эдийн засгийн нөгөө түүчээ болсон уул уурхайн салбар, энэ том аж ахуйн нэгжүүд бол асуудал өөр.

**Л.Энхнасан:** Болчихсон уу? Гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Байхгүй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028, 2029 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёрдугаар хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара танилцуулна.

Хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе.

**Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нарын 4 гишүүнээс 2025 оны 3 сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын төрөлжсөн мэргэшсэн тусламж хариуцсан ахлах шинжээч, Халиун Ажлын хэсгийг оруулна уу Халиун Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Үйлдвэрлэлийн тасгийн технологич их эмч, Тунгалагтуяа Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Цусны чанар аюулгүй байдлын албаны дарга.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Баясгалан гишүүний микрофоныг өгнө үү.

**Ж.Баясгалан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурал 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил ,нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасан ний дагуу зарчмын зөрүүтэй 4 санал дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Цусны донорын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 4 саналыг гүйцээн боловсрууллаа.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Цусны донорын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Байхгүй байна. Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын даргын гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу зарчмын

зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 4 саналтай. Байнгын хорооны гишүүд санал хураалтад бэлдэнэ үү.

Цусны донорын тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

1 дүгээрт, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль,” гэснийг хасаж, мөн хэсгийн “Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэсний дараа “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль,” гэж нэмэх. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн сана саналын томьёоллоор санал хураалт.

26 гишүүн оролцож 17 гишүүн дэмжиж, 65.4 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлийг нэгтгэн 19 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах,  
урамшуулах, дэмжлэг үзүүлэх**

19.1.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагааг Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага нь цусны донорыг элсүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Цусны донорын эгнээг өргөжүүлэх, хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагаанд сайн дурын ажилтан, иргэн оролцож болно.

19.4.Цусны байнгын донорт цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн тооноос хамаарч Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагаас баталсан журмын дагуу энэ хуулийн 10.2.10-т заасан тэмдгийг олгоно.

19.5.Цусны донорыг “Цусны хүндэт донор” цол тэмдгээр дараах шалгуурын дагуу шагнаж, алдаршуулна:

19.5.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.2.цусаа 35 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.5.3.ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш удаа өгсөн.

19.6.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

19.7.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

18.8. уучлаарай. 19.8.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор магадлан итгэмжлэгдсэн дотоодын сувилалд Засгийн газраас тогтоосон сувиллын жишиг үнийн дагуу жилд нэг удаа сувилуулах бөгөөд холбогдох журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.9.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор аймаг, нийслэлийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчино.”

19.10.“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүндэт донор”, “Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүндэт донор” цол тэмдэгтэй иргэнд энэ хуулийн 19.8, 19.9-д заасан дэмжлэг хамаарна.”. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Ганхүлэг гишүүн тодруулга, асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Өмнөх хэлэлцүүлэгтэй зүйл тус бүрээр нь ярих юм байх гэж бодоод түрүүн ойлгосонгүй. Энэ 19.5 дээр бас өмнө нь Байнгын хороо, Их Хурал дээр бас санал хэлээд байгаа юм. Цусны хүндэт донор гэдэг энэ цол тэмдгийг зэрэглэлтэй болговол болохгүй юу гэсэн саналыг бас хэлээд байгаа. Тэгээд энэ талаар ажлын хэсэг дээр ярилцаад буцаад ингээд ийм саналаараа бас орж ирсэн байна. Тэгээд та хэд маань хоорондоо ярилцав уу? Ямар үндэслэлээр шаардлагагүй гэж бас үзсэн юм бол оо? Эс үгүй бол энэ тухай зүгээр ингээд орхигдуулаад бас явчхав уу? Улаан загалмай нийгэмлэг дээр энэрэнгүй үйлстэн гэдэг юм уу тийм 10 хувьд хэд хэд дээр бас байгаа гэж ойлгоод байгаа. Тэгэхдээ яах вэ дотор нь бас айхтар ялгахгүйгээр 1, 2, 3 дугаар гэдэг ийм зэрэг олгоод заавал эхний зэргүүд дээр нь бас шагнал, урамшуулал янз бүрийн юм байхгүй байж болно.

Гэхдээ 10 удаа цусаа өгнө гэдэг бол бас тийм бага биш. 20 удаа өгнө гэдэг бол бага биш. Тэгэхээр хүн болгон бас ингээд ийм 7, 8 жил тасралтгүй өгөөд 35 хүргэнэ гэдгээ бас ийм ганцхан ийм шалгууртай биш, ийм шатлалтай болгоод өгчхөөч ээ. Хэд хэдэн улсууд дээр ийм шатлал хийснээрээ давуу тал бол гарсан байна. Төсөв дээр ямар нэгэн дарамт байхгүй. Тодорхой янз бүрийн юман дээр бас дарамт байхгүй.

Тэгэхээр энэ хүндэт донорын энэ болзол гэдэг хуучин байснаасаа бол үндсэндээ бол эрх зүйн байдлыг нь жоохон дордуулсан ийм нөхцөл байдлыг бид нар санал болгож байна. Уул нь энэ хууль гаргаж ирэх тусмаа илүү давуу байдлууд бол бий болоод явах ёстой гэдэг энэ үндэслэлүүдийг би бас зөндөө хэлсэн. Тэгээд энэ талаар та хэд маань бол ярилцсан уу? Тэгээд энийг уул нь 10 дээр байдаг юм уу 20 дээр 1, 2 дугаар зэрэглэл болгоод ингээд бас хүмүүсийг явцын дунд нь урамшуулбал улам л идэвхжих ийм л энгийн ийм зүйлс байгаад байгаа юм. Тэгээд энийг шийдчихэж болохгүй байсан уу гэдгийг асууя.

**Л.Энхнасан:** Ажлын хэсгийн дэд хорооноос хариулна уу? 6 дугаар микрофон. 6 дугаар микрофон дахиад өгнө үү?

**Э.Тунгалагтуяа:** Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Тусламж, үйлчилгээний чанарын аюулгүй байдлын албаны дарга Тунгалагтуяа. Ганхүлэг гишүүний асуултад мэдээлэл, хариулт өгье. Бид нар яг Монгол Улсын хэмжээнд цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгснөөс шалтгаалаад ямар хэмжээтэй өгч байгаагаас шалтгаалаад, хэд хэдэн удаа өгч байгаагаас шалтгаалаад бас “бахархал” тэмдгүүд, алт, мөнгө, хүрэл, мөнгөн донорууд гэсэн тэмдгүүд бид нар бол олгож явж байгаа.

Энэ нь бол яг “хүндэт донор” цол тэмдгээ авсны дараа мөн 50 болон 70 удаа, 100 удаа, 150 удаа өгөлтөөсөө шалтгаалаад бас энэ тэмдгүүдийг өгч байгаа нь энэ цусны хүндэт доноруудаа мөн алдаршуулж, урамшуулж байгаа энэ чиглэл рүү орж байна.

Тэгээд энэ заалтаа бид хэд энэ хуулийн 19.4 дүгээр заалт дээр мөн тусгаж оруулсан байгаа. Цусны байнгын донорт цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн тооноос хамаарч яг цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагаас баталсан журмын дагуу тэмдэг олгоно гээд. Энэ тэмдгүүдэд нь бол цус өгөлтийн тооноос хамаараад 10 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн бол “бахархал 10” тэмдэг 20 удаа өгсөн бол “20”, 30 удаа өгсөн бол “30”, 40 удаа бол “бахархал 40, 50” гээд эдгээр тэмдгүүдийг олгоно.

Мөн 70-100 удаа өгсөн бол “хүрэл донор”, 100-150 өгсөн бол “мөнгөн донор”, 150-аас дээшээ бол “алтан донор” гээд ийм зэрэглэлүүдийг гаргаж ирсэн байгаа. Тэгэхээр энэ маань бол энэ заалттай уялдаад гарч ирж байгаа юм гэж үзэж байгаа учраас бид хэд ингээд энэ тоог хэвээр үлдээхээр ажлын хэсгээр ярилцсан.

**Л.Энхнасан:** Ганхүлэг гишүүн тодруулга нэмж асуух уу? Ганхүлэг гишүүн.

**М.Ганхүлэг:** Хууль дээрээ тусгах тухай асуудлыг яриад байгаа юм манайхан. Тэр журмыг бол яах вэ ойлгосон тийм. Яах вэ тэр тусдаа журмаар зохицуулаад ингээд явахын шалтгаан юу байгааг би бас ойлгохгүй байна л даа. Зүгээр энэ цусны хүндэт донор байгаа гэдэг дээрээ 1, 2, 3 гэдэг юмыг нь зэрэглэл тогтоогоод оруулчихвал яасан юм бэ л гэсэн ийм санаа байгаа юм. Тэгээд энэ доноруудаа бас бид нар дотор нь ийм ялгамжтай байдлууд бас бий болгох эрсдэл байх уу үгүй юу? Засгийн газрын шагналаар зарим нь аваад, зарим нь болохоор Улаан загалмайн шагнал болоод, зарим нь журмаар зохицуулагдаад ч гэдэг юм уу ингээд ийм ойлгомжгүй байдлууд бас үүсэж байхаар ер нь 1, 2 3 гэдэг ангиллаараа оруулчихвал яасан юм бэ л гэсэн ийм санаа л даа. Тэгээд та хэд маань яг энийг ярилцсан юм уу? Дахиад тодруулъя яагаад ийм ялгамжтай байгаа юм бэ?

**Л.Энхнасан:** 6 дугаар микрофон. Бүүр яг тодорхой сайн тайлбарлаад өгөөч.

**Э.Тунгалагтуяа:** Цус, цусны бүрэлдэхүүн хэсэг гэж хэлээд байгаа нь бол тухайн бүхэл цус буюу бид нар эрэгтэй хүн бол 2 сарын зайтай, эмэгтэй хүн бол 3 сарын зайтай цусаа өгч байгаа. Энэ бол бүхэл цусыг хэлж байгаа. Тусгай аппаратын тусламжтайгаар хүний цуснаас сийвэнг нь ялгаж авч байгааг цусны бүрэлдэхүүн хэсэг гэж хэлж байгаа.

Тэгэхээр энэ нөгөө цусны бүрэлдэхүүн хэсэг үү, бүхэл цус уу гэдгээсээ ялгаатайгаар энэ тоо гарч ирсэн байгаад байгаа л даа. Тэгэхээр нөгөө цус, цусны бүрэлдэхүүн хэсэг буюу сийвэнгээ, бүхэл цусаа өгч байгаа тохиолдолд бид нар 50

гэж заагаад, бүхэл цусаа өгч байгаа нь бол 35 гээд арай багаар ингээд тодорхойлж өгсөн байгаад байгаа.

Тэгээд сийвэнгийн өгөлтийн хугацаа бол 14 хоногийн зайтай байдаг. Эрэгтэй хүн бол 2 сар тутамдаа цусаа өгөөд, үүний дараа цусаа өгсний дараа 14-ийн зайтай бүхэл цусаа өгч байгаа ийм процесс.

**Л.Энхнасан:** Гишүүн арай өөр юм асуугаад байна л даа. Ганхүлэг гишүүн дахиад тодруулга хийе, тодруулж асууя.

**М.Ганхүлэг:** Цусны бүрэлдэхүүний хэсэг, бүхэл цусаа ойлгож байгаа. Тэрийг мэдээд байгаа. Тэрийг асуугаагүй. Хүндэт донорын энэ ангиллаа нэгийг нь ингээд хуульдаа оруулаад бид нар ингээд баталгаажуулж байна шүү дээ. Тэгээд Засгийн газрын шагнал олгоод, илүү давуу эрх олгоод ингээд явж байна. Бусдыг нь болохоор ингээд журмаар зохицуулна гэж ялгаж байна. Ингэлгүйгээр хуульдаа 1, 2, 3 гэдэг ийм зэрэг оруулаад явчихаар яг юу нь болохгүй байгаа юм бэ л гэдэг асуулт асуугаад байна шүү дээ. Тэгээд ийм саналын тухай та хэд ажлын хэсэг дээр ярилцсан юм уу? Ярилцсан юм уу? Ингээд хуулиараа нэгэнт бид нар хуулийн асуудал яригдаж байгаа учраас хуулиараа ингээд зэрэглэлтэй болгоод дэмжээд өгчихвөл яасан юм бэ гэдэг энэ саналын тухай л яриад байна. Тэгээд энийг яг тодорхой хариулаад өгөөч.

**Л.Энхнасан:** Ажлын хэсгийн ахлагч Баясгалан гишүүн хариулаад өг. Ажлын хэсгийн дарга хариулъя. Баясгалан гишүүн.

**Ж.Баясгалан:** Энэ дээр давхардаад байгаа болохлоор оруулаагүй хуульдаа 19.4 дээр бол түрүүн бас тайлбарлалаа цусны байнгын донор цус, цусан бүрэлдэхүүн хэсгээ өгсөн тооноос хамаарч Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагаас баталсан журмын дагуу 10.2.10-д заасан тэмдгийг олгоно гэсэн байгаа. Тэгээд энийг бол ажлын хэсэг дээр бол удаа дараа ярьсан. Удаа дараа санал хураасан. Тэгээд шийдсэн шийдэл ээ.

Энэ дээр чинь бас нэмэгдээд маш олон юм байгаа шүү дээ. 120 удаа цус өгсөн буюу түүнээс дээш өгсөн хүнд Ерөнхийлөгчийн зарлигаар “Шударга журам” медаль олгодог. Ингээд энэ заалтууд бол бүгдээрээ байгаа учраас энийг хууль дээрээ заавал тусгах шаардлагагүй гэж үзсэн байгаа шүү.

**Л.Энхнасан:** Ингээд энэ саналаа дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

26 гишүүн оролцож, 17 гишүүн дэмжиж, 65.4 хувиар дэмжигдлээ.

Гишүүд маань санал хураалтдаа анхаарна уу.

3 дугаар заалт. Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тээвэрлэх үйл ажиллагааг” гэсний дараа “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 15.1.12-т заасан” гэж нэмж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.12-т заасан эрүүл мэндийн байгууллага нь цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах

зориулалтаар тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглан энэ хуулийн 22.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

26 гишүүний 19 гишүүн дэмжиж, 73.1 хувиар дэмжигдлээ.

Сүүлийн санал. 4.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 25.4 дэх хэсгийн “сан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр цусны төв, цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэгч эрүүл мэндийн байгууллагуудтай” гэснийг “эрүүл мэндийн мэдээлэл солилцсоны нэгдсэн системтэй” гэж өөрчилж, мөн зүйлийн 25.5 дахь хэсгийг хасах:

“25.3.Энэ хуулийн 25.2-т заасан мэдээллийн сангийн үйл ажиллагаа нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцсэн байна.”. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

26 гишүүнээс 18 гишүүн дэмжиж, 69.2 хувиар дэмжигдлээ. Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нарын 4 гишүүнээс 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт явуулж дууслаа. Хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаан Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Баярлалаа. Одоо дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

16.52 цаг

**Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа, Баасанжаргал, Баярбаатар, Уянга, Эрдэнэбат, Эрдэнэболд нарын 6 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсэг Даваажаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Отгонбилэг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Номин-Эрдэнэ Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын багцын төсвийн урсгал зарлага хариуцсан шинжээч.

Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Отгоны Саранчулуун танилцуулна. Саранчулуун гишүүний микрофоныг өгнө үү.

## **О.Саранчулуун:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун, гишүүдэд Н.Алтаншагай, Д.Бум-Очир, Д.Ганмаа, М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа, М.Сарнай, Г.Хосбаяр, Л.Энхнасан нар ажиллалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг 2 удаа хуралдаж, 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Хүн ам зүйн бодлого, асуудал, шийдэл сэдэвт хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүд, Эрүүл мэндийн яам? Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, салбарын эрдэмтэн, судлаачид, иргэдийн төлөөлөл зэрэг нийт 130 хүн оролцсон хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлгээр хүн амын өсөлт, төрөлтийг дэмжих бодлого нь зөвхөн хүүхэд төрүүлэхийг уриалсан агуулгаар хязгаарлагдах бус хүүхэд төрсний дараах амьдралын чанар, эх, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал, хөгжлийн тэгш боломжийг цогцоор нь авч үзэх шаардлагатайг онцолсон.

Мөн салбарын судлаачид мэргэжилтнүүдийн илтгэл, дүгнэлтэд үндэслэн Монгол Улс хүн ам зүйн аюулгүй байдлаа хангахын тулд эх, нярай нялхсын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, боловсрол болон нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, залуу гэр бүлийг эдийн засаг, орон сууц, ажил, амьдралын тэнцвэрийн бодлогоор дэмжих шаардлагатай байгааг тэмдэглэлээ.

Түүнчлэн ажлын хэсгийн зүгээс энэхүү хуулийн төслийн хүрээнд 1 нас хүрсэн байх гэдэг шалгуурыг хасах нь зөвхөн хүн амын өсөлтийг дэмжих асуудал биш харин хүүхэд төрүүлсэн эхчүүд болон хүүхдүүдийг нөхцөл байдлаар нь ялгаварлан гадуурхах эрсдэлийг бууруулах, хүүхэд бүрийн үнэ цэнийг ижил түвшинд хүлээн зөвшөөрөх эрх зүйн зарчимтай нийцэж байна гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл, хүүхэд төрүүлсэн эхийг урамшуулах бодлого нь амьдралын нөхцөл байдал, эрүүл мэндийн эрсдэл, хүүхдийн эндэгдэл зэрэг эмзэг асуудлаас үүдэн зарим эхийг төрөөс дэмжлэг авах эрхгүй болгож болохгүй юм.

Иймд 1 нас хүрсэн байх гэсэн шаардлагыг хасах нь хүний эрх, тэгш байдлын зарчимд нийц зохицуулалт болно гэж ажлын хэсэг дүгнэж байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгийн гишүүдээс боловсруулсан 2 зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр

хэлэлцэнэ гэж заасан. Гишүүн хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй, тийм төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу?

Байхгүй байна. Хэн асууна гэсэн? Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу.

**А.Ариунзаяа:** Яах вэ маш хүнд сэдэв. Ээжүүдийг ялгаварлаж болохгүй, хүүхэд төрүүлснийг нь үгүйсгэж болохгүй гэж байгааг бол бид хүлээн зөвшөөрөөд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явсан. Тэгээд эхний хэлэлцүүлэг болж байна. Би цаашид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бас анхаарах хэд хэдэн асуудал байгаа гэдгийг энд зүгээр протоколд тэмдэглэж үлдээх гэсэн юм.

Нэг дэх нь болохлоор хууль батлагдлаа гэхэд ямар ч хууль нөхөн үйлчилдэггүй. Тэгэхээр нийгэмд үүсгээд байгаа хүлээлтийг нөхөн одон олгох юм шиг ийм бас ойлголт яваад байна лээ л дээ. Тэгэхээр энэ дээр бас анхаарч та хэд маань явахгүй л бол 1 хууль дээр нөхөн үйлчилдэг, нөгөөдүүл дээр нөхөн үйлчилдэггүй ийм хуулийн ерөнхий энэ нөгөө концепц, логик нь алдагдаад явах юм бол тэгээд ер нь бүхий л хуулиуд дээр нөхүүлэх ёстой гээд л тэгээд л ер нь хэцүү шүү дээ. Та хэд маань ойлгож байгаа байлгүй дээ энийг. Тэгээд хууль зүйн үндэслэл талаас нь та хэд маань бас бодно биз.

Хоёр дахь нь болохлоор хүүхэд төрүүлээд үрчлүүлэх асуудлыг ч гэсэн дараад нь нөгөө дөнгөж төрөнгүүт нь одонгоо аваад явчихдаг, тэгээд өөрөө эргээд хүүхдээ хүмүүжүүлдэггүй, бусдад өргүүлдэг, эс үгүй бол асрамжийн газар орхидог зэрэг энэ асуудлууд дээр уул шугамдаа уг нь эцэг, эхэд нь бас асуудлыг бид нар ярьдаг байх ёстой. Тэгэхээр энэ агуулгаараа хүүхдүүдийн бүртгэл болон энэ “Алдарт эх”-ийн одон авч байгаа мэдээж бүгдээрээ л сайн ээжүүд гэж бид нар хүлээж байгаа. Гэтэл цаана нь бол бас өөр асуудлууд байдаг гэдгийг манай яамныхан гарцаагүй мэдэж байгаа учраас үүн дээрээ бас анхаарч яваарай. Ямар нэгэн байдлаар зүгээр одон авахын төлөө тэгээд дараад нь нэг нэгэндээ хүүхдээ үрчлүүлчихдэг ийм асуудал бас гараад байдгийг бид нар ний нуугүй мэддэг учраас энийгээ бас анхаараарай.

Цаашлаад бидний тэжээгчээ алдсаны тэтгэмж ч гэсэн яадаг билээ дээ тээ эмээ, өвөөдөө өндөр настай хүмүүстээ өвлүүлээд, эргээд үрчлүүлээд явж байгаа түүнийгээ эргээд юу гэдэг юм өөрөөр тайлбарлаж явдаг асуудлыг ч гэсэн бид нар цэгцлэхгүй бол болохгүй шүү. Тэгэхээр энийг бас манай Нийгмийн хамгааллын яамныхан анхаарч үзээрэй гэж хүсэж байна.

Нярайн эндэгдэл болоод хүүхдийн бага насны эндэгдлийг бууруулахын тулд бид дөнгөж төрсөн нярай дээр бас юу гэдэг юм долоо хоног, 2 долоо хоногийн нярайн сувиллын асуудлыг ч гэсэн төрөөс бодлогоор анхаарах ёстой юм байна лээ шүү. Тэгж байж тухайн хүүхдийн эрүүл мэндэд, ээжийн ч гэсэн сэтгэл санаанд ч гэсэн сайнаар нөлөөлнө.

**Л.Энхнасан:** Үг хэллээ. Байнгын хорооны гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Ажлын хэсэг саналтай. Үг хэлж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн “тэр үед гурав хүртэлх насанд гэж”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун, Алтаншагай, Бум-Очир, Ганмаа, Ганхүлэг, Мөнхтуяа, Сарнай, Хосбаяр, Энхнасан цаашид ажлын хэсэг гэх. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

26 гишүүнээс 17 гишүүн дэмжиж 65.4 хувиар дэмжигдлээ. Баярлалаа.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт хийе. Санал хураалт.

26 гишүүнээс 18 гишүүн дэмжиж, 69.2 хувиар дэмжигдлээ.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Отгоны Саранчулууныг томилъё.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье. Баярлалаа гишүүддээ.

17.03 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.ОТГОНДЭЛГЭР*